


ЗАМ ТЭЭВРИЙН

СЭРГЭЭЛТ



ДАЛАЙД ГАРЦГҮЙ Ч
ДЭЛХИЙД ГАРЦТАЙ МОНГОЛ

ШИНЭ СЭРГЭЛТИЙН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД
**11 БООМТЫГ АВТО
ЗАМААР, 4 БООМТЫГ
ТӨМӨР ЗАМААР**
ХОЛБОНО

УЛААНБААТАР ТӨМӨР
ЗАМ ХНН-ИЙН ИХ ӨРИЙГ
ТЭГЛЭЖ, ДҮРМИЙН
САНГ **167 ТЭРБУМААР**
НЭМЭГДҮҮЛЛЭЭ

ОРОН НУТГИЙН
НИСЛЭГ СЭРГЭЖ,
ТИЙЗИЙН ҮНИЙГ
2-2,5 ДАХИН
ХЯМДРУУЛЛАА

Welcome to Mongolia



МЭНДЧИЛГЭЭ

Амархан сайн байцгаана уу. Урагшлах хөгжлийн аян замаа бэлгэшээн ерөөж, ухаан бодолдоо алс ирээдүйгээ зөгнөн хурайлсан зам, тээврийн салбарынхандаа Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэнд хүргэе.

Бид энэ оныг “Бүрэн цахимжсан бүтээмжийг нэмэгдүүлж хариуцлага, үр дүнг тооцох жил” болгон зарласан билээ. Төмөр замын салбарт УБТЗ-ын олон жил ужирсан 200 тэрбум төгрөгийн их өрийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, дүрмийн санг 167 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, таван шинэ зүтгүүрээр хөдлөх бүрэлдэхүүнээ шинэтгэх бололцоог нээн, 16 мянган төмөр замчныхаа цалин хөлс, урамшууллыг нэмэх бодит боломжийг бүрдүүлж чадлаа. ОХУ-ын транзит тээвэрт үзүүлдэг асан тарифын хөнгөлөлтийг 10 хувь бууруулж чадлаа. Улаанбаатар-Хархорум чиглэлд Монголын анхны хурдны төмөр замын төсөл хэрэгжүүлэхээр зорьж холбогдох зураг төслийг боловсруулж байна. “Хөгжлийн судас төмөр зам” бодлогын хүрээнд үндэсний төмөр замын сүлжээг улам өргөтгөн Зүүн болон Баруун чиглэлийн босоо төмөр замын төслийг хэрэгжүүлж Гашуунсухайт-Ганц мод, Бичигт-Зүүнхатавч, Шивээхүрэн-Сэхээ боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлж, Ханги-Мандалын хил холболтын төмөр замыг ойрын үед барих саналыг Хятадын талд тавиад байна. Зүүн босоо чиглэлийн төмөр замын төслийн нэгээхэн хэсэг болох 1.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжүүд орж ирэн ажилдаа орлоо.

Иргэний нисэхийн салбарт “Хямд тийз-хүртээмжтэй нислэг” бодлого дэвшүүлж дэлхийн 40 улсын 105 цэг рүү нисэх боломжийг нээн, нислэгийн чиглэл давтамжийг эрс нэмэгдүүлж, олон оронтой



агаарын тээврийн хэлэлцээр байгуулснаар нислэгийн үнэ хямдарч, үйлчилгээ чанаржиж байна. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил”, орон нутгийн хөгжлийг тэтгэх “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд орон нутгийн найман чиглэлд нислэг сэргэж тийзний үнийг 2-2.5 дахин хямдрууллаа.

Авто замын салбарт бид “Чанартай зам-чансаатай засвар арчлалт” бодлого дэвшүүлэн энэ онд 500 км авто зам, 540 у/м төмөр бетон гүүр шинээр ашиглалтад оруулж, олон зуун км замд их болон ээлжит засвар хийхээр ажиллаж байна. Урд хойд хөрш, Ази Европыг холбосон АН-4 буюу баруун босоо тэнхлэгийн 745 км авто замаа бүрэн ашиглалтад оруулж, транзит тээврийг эхлүүлж, дэлхийн олон оронтой авто тээврийн хэлэлцээр байгууллаа. Далайд гарцгүй ч дэлхийд гарцтай Монгол байхын тулд далайн тээврээс хүртэх улсын эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, Тяньжин боомт дахь Монгол Улсад эзэмшүүлсэн талбайг үр ашигтай ашиглах талд илүү санаачилгатай, хурдтай байхыг зорьж байна. Энэ ташрамд хөгжлийн хүрдийг атгаж, хурд нэмсэн Зам, тээврийн хөгжлийн салбарын 42 мянган ажилтан албан хаагчид, төмөр замчид, авто замчид, жолооч тээвэрчид, агаарын тээврийн салбарынхандаа давшингүй их амжилт, дэвшингүй дүүрэн жаргалыг хүсье. Агаарын хөлгийн тэнгэр нь цэлмэг, буулт нь зөөлөн, алтан шар замын ерөөл нь арвин, буян нь дэлгэр, газрын жигүүр төмөр зам алсад тод зурайж галт тэрэг улам хурдалж байх болтугай!



АГААРЫН ТЭЭВРИЙН СЭРГЭЛТ

“ХЯМД ТИЙЗ-ХҮРТЭЭМЖТЭЙ НИСЛЭГ”

ОРОН НУТГИЙН НИСЛЭГИЙГ
ДАХИН СЭРГЭЭЖ, ТИЙЗИЙН
ҮНИЙГ **2-2,5 ДАХИН**
ХЯМДРУУЛЛАА



ЭНЭ ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД НИЙТДЭЭ 495 МЯНГАН
ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЖ, 2022 ОНЫ МӨН ҮЕТЭЙ
ХАРЬЦУУЛАХАД 216 ХУВИЙН ӨСӨЛТ ҮЗҮҮЛЭЭД БАЙНА



Монголын агаарын тээврийн зах зээл гадаадын болон дотоодын нислэгтэйгээ нийлээд 1.6 сая зорчигчийн багтаамжтай гэх тооцоо бий. Энэхүү зах зээлд төрийн өмчийн МИАТ компаниас гадна хувийн хэвшлийн компаниуд зэрэгцэн оршиж байна. Аливаа зах зээлийн өрсөлдөөн нь хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүний нэр

төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, тэр хэрээр үнийг бууруулж, үйлчилгээг сайжруулж байдаг зүй тогтолтой. Агаарын тээврийн салбарын либералчлал энэхүү зарчимд суурилж, шударга тэгш өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, энэ нь салбарын хөгжлийг хөдөлгөх хүчин зүйл болохуйц бодлогыг хэрэгжүүлж байна.

ОРОН НУТГИЙН НИСЛЭГ СЭРГЭЛЭЭ



Монгол Улс зүүнээс баруун тийш сунаж тогтсон өргөн уудам газар нутагтай. Өргөн уудам нутагт дотоодын агаарын тээвэр зайлшгүй хөгжих ёстой чухал салбар юм. Хөгжих зах зээл, ирээдүй бүхий дотоодын агаарын тээвэрт МИАТ компани 2008 оноос хойш зогсоогоод байсан есөн чиглэлд нислэгээ эхлүүлээ.

ОРОН НУТГИЙН НИСЛЭГ ҮЙЛДЭХ ЧИГЛЭЛҮҮД:




Улаанбаатар
Ховд аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Баян-Өлгий аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Увс аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Завхан аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Говь-Алтай аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Хөвсгөл аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Өмнөговь аймаг
Улаанбаатар



Улаанбаатар
Дорнод аймаг
Улаанбаатар

ОРОН НУТГИЙН 8 ЧИГЛЭЛД НИСЛЭГ СЭРГЭЖ, ТИЙЗИЙН ҮНЭ 2-2,5 ДАХИН ХЯМДАРЛАА


Орон нутгийн 8 чиглэлд нислэг сэргэж, 2023 оны долоодугаар сарын 01-нээс эхлэн тогтмол нислэг үйлдэж эхэллээ.

Тодруулбал, Ховд, Өмнөговь, Алтай, Увс, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад, Улиастай, Өлгий чиглэлд долоо хоногт 1-3 удаагийн давтамжтай нисэхээр болж, тарифыг 2-2.5 дахин буурууллаа.


ӨЛГИЙ, ХОВД ЧИГЛЭЛ	ДАЛАНЗАДГАД ХОТ хоёр талдаа 500,000-617,000,	УЛААНГОМ, УЛИАСТАЙ ЧИГЛЭЛ
нислэгийн тийз хоёр талдаа	МӨРӨН ХОТ 500,000-680,000,	нислэгийн тийз хоёр талдаа
өмнө 1,5-1,7 сая	АЛТАЙ ХОТ 733,000-852,000,	өмнө 1,3-1,4 сая
одоо 810-902 мянга	ЧОЙБАЛСАН ХОТ 537,000-617,000 төгрөгний тарифаар нислэг үйлдэнэ.	одоо 633-852 мянга

Тарифын хувьд Өлгий чиглэлд хоёр талдаа 1 сая 700 мянга байсан бол, 810-902 мянга, Ховд руу 1 сая 500 мянга байсан бол 810-902 мянга, Улаангом руу 1 сая 400 мянга байсан бол 800-852 мянга, Улиастай руу 1 сая 300 мянга байсан бол 633-752 мянга болж 2-2.5 дахин хямдарч байна.

Мөн Даланзадгад руу хоёр талдаа 500-680 мянга, Мөрөн рүү 500-680 мянга, Алтай 733-852 мянга, Чойбалсан руу 537-617 мянган төгрөгийн тарифаар нислэг үйлдэнэ.



Нислэгийн турш өөрийн дуртай контентоо зөврийн төхөөрөмжөөрөө үзэх боломжтой боллоо



Google Chrome Apple Safari

www.miat.com 11 333 999

Орон нутагт нислэг сэргэсэнээр, хөдөөгийн сэргэлтэд хөшүүрэг болж, өндөр настан, нялх хүүхэдтэй, өвчтэй иргэд агаарын тээврээр шуурхай, хямд зорчих боломж бүрдэж байна. Мөн Ховд, Мөрөн, Даланзадгад, Чойбалсан гэсэн орон нутгийн дөрвөн нисэх буудлыг олон улсын зэрэглэлтэй болгоход ихээхэн ач холбогдолтой юм. Зам, тээврийн хөгжлийн яам түүний харьяа байгууллага “МИАТ” ТӨХК нь ийнхүү орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэж эхэлснээр дотоодын зорчигчид болон Монгол орныг зорин ирж буй гадаадын жуулчид хямд үнээр, хүртээмжтэй, тав тухтай, шуурхай зорчих боломж бүрдэж, орон нутгийн нислэг сэргэлээ.

МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал

Б.МӨНХТАМИР:**МИАТ ТӨХК
ОРОН НУТАГТ
ДОЛОО ХОНОГТ
1-3 УДААГИЙН
ДАВТАМЖТАЙ
НИСЛЭГ ҮЙЛДЭЖ
ЭХЭЛЛЭЭ**

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласан. Энэ хүрээнд орон нутгийн нислэгийг сэргээж, МИАТ ТӨХК нислэг үйлдэхээр боллоо. Энэ талаар тодруулбал?

Манай МИАТ ТӨХК-ийн хувьд Монголд зочлох жилийн хүрээнд зарим чиглэлд нислэгийн давтамж, суудлын тоог нэмэгдүүлээд байгаа. Үүний үр дүнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар гэхэд зөвхөн манай компани 332 мянга 315 зорчигч тээвэрлэсэн. Энэ оны долоодугаар сарын 1-нээс эхлэн орон нутгийн есөн чиглэлд долоо хоногт 1-3 удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэж эхлээд байна. Эхний ээлжинд Чойбалсан, Мөрөн, Ховд, Өлгий, Алтай, Улаангом, Даланзадгад, Улиастай гэсэн 8 аймагт нислэг үйлдэж, удахгүй Баянхонгор аймгийн нисэх буудлын зурвас шинэчлэгдсэний дараа тус аймаг руу нислэг үйлдэх төлөвлөгөөтэй байгаа. Манай улс зах зээлийн нийгэмд шилжсэн сүүлийн 30 жилээр тооцоолбол, 2008 он хүртэл МИАТ ТӨХК орон нутагт нислэг үйлддэг байсан.

Олон нийтийн сүлжээнд тийзний үнэ өндөр байна гэсэн шүүмжлэл гардаг. Тэгэхээр өмнөх үнээс 2 дахин хямдарсан гэж ойлголоо?

Орон нутгийн нислэгийн тийз өнгөрсөн хугацаатай харьцуулахад 2-2.5 дахин хямдарсан. Нислэгийн тасалбарыг эрт авснаар

илүү хямд захиалах ч боломжтой байдаг. Орон нутгийн нислэгийн тарифт мөн нэмэгдсэн өртгийн албан татвар тооцогдоно.

Ер нь тийзний үнэд юу багтдаг вэ?

-Нислэгийн тийз маш олон төрлөөс бүрэлддэг. Нэгдүгээрт, тухайн агаарын тээвэрлэгчийн үндсэн тариф дээр нисэх буудлуудын такс, аюулгүй ажиллагааны ажилчдын хураамж нэмэгдэнэ. Эдгээр хураамжийг тийзний үнэд шингээж аваад буцаагаад нисэх буудлуудад дамжуулан өгдөг. Өөрөөр хэлбэл, авиа компаниуд дамжуулах үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг. Нөгөө талдаа, 250 хүний суудалтай агаарын хөлгөөр нислэг үйлдлээ гэж тооцоход 17 төрлийн тийз байдаг. Нөхцөл, хэрэгцээ шаардлагаас хамааран тус бүр өөр үнэтэй байна. Энэ систем нь зөвхөн МИАТ ТӨХК дээр хэрэгждэг зүйл биш. Олон Улсын агаарын тээврийн холбооноос баталсан журам тул дэлхийн бүх агаарын тээвэрлэгчид хэрэглэдэг. Иргэд ажлаа төлөвлөн, тийзээ эрт захиалан авах нь зорчигч, тээвэрлэгч хоёуланд нь давуу талтай. Зорчигч тийзээ хямд үнээр худалдан авч байгаа бол тээвэрлэгчид суудлын ачаалал, дүүргэлтээ төлөвлөх боломж олгодог.

Мэдээлэл лавлагааны төв
24 цагаар ажиллана

11-333999

www.miat.com



МОНГОЛ УЛСЫН ОРОН НУТГИЙН НИСЭХ БУУДЛУУДЫГ 4С БОЛГОХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ



Орон нутгийн нисэх онгоцны буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг эхлүүлж, ХОВД, МӨРӨН, ЧОЙБАЛСАН нисэх буудлыг 4С, Өмнөговь аймгийн ГУРВАНСАЙХАН нисэх буудлыг 4D ангилалд шилжүүлнэ. Ингэснээр дээрх нисэх буудал нь А320, В737, ИЛ-76 маягийн том агаарын хөлөг хүлээн авах, нэг цагт 300-500 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болж, зорчигч урсгал нэмэгдэнэ.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР “ТУСГАЙ ТАРИФ” ГАРГАЖ, ТИЙЗИЙН ҮНИЙГ БУУРУУЛЛАА

“Хямд тийз-Хүртээмжтэй нислэг” бодлогын хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор групп зорчигчийн болон өвлийн аялал жуулчлалд зориулан тусгай тариф гарган зорчигчдод санал болгож байна. Өвлийн аялал жуулчлалыг дэмжих тариф нь 10-р сарын 01-нээс 4-р сарын 30 хүртэл, аялал жуулчлалыг дэмжих групп тариф нь 5-р сарын 01-нээс 9-р сарын 31-ний өдөр хүртэл мөрдөгдөх бөгөөд нөхцлийн хувьд уян хатан, дундаж тарифаас 15-40 хувийн хямдралтай.




АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УРСГАЛЫГ ХАНГАХ ЗОРИЛГООР НИСЛЭГИЙН ДАВТАМЖ, ТООГ НЭМЭГДҮҮЛЛЭЭ



МИАТ ТӨХК Ази, Европын чиглэлд нислэгийн сүлжээгээ өргөжүүлэх, зах зээлд гаргах суудлын тоог нэмэгдүүлэх бодлого барьж ажиллаж байна. 2023 онд 2900 нислэг үйлдэх зорилго тавин ажиллаж байгаа төдийгүй энэ оны зуны нислэг, аялал жуулчлалын оргил үед, Европын чиглэлд



Франкфурт хот руу долоо хоногт 6, Истанбул хот руу долоо хоногт 3, Азийн чиглэлд Сөүл хот руу өдөрт 2-3, Бээжин, Хонконг, Токио руу өдөр бүр, Гуанжоу руу долоо хоногт 2, Пусан руу долоо хоногт 4 удаа, Осака руу долоо хоногт 2 удаа болгон нислэгийн давтамжийг нэмэгдүүллээ.



НИСЛЭГИЙН ҮЕИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛЖ, БИЗНЕС ЛОУНЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Зорчигч үйлчлүүлэгчиддээ тав тухтай үйлчлэх зорилгоор МИАТ ТӨХК нь Бизнес лоунжийн үйлчилгээг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс нэвтрүүллээ. Байнгын үйлчлүүлэгчийн Блю Скай картын гишүүд хөнгөлөлттэй нөхцлөөр МИАТ-Бизнес лаунжаар үйлчлүүлэх боломжийг бүрдүүлээд байна.



ИНЕГ-ын дарга

Ч.МӨНХТУЯА:

“ МОНГОЛ УЛС 40
УЛСТАЙ АГААРЫН
ХЭЛЭЛЦЭЭР
БАЙГУУЛЖ, 105
ЧИГЛЭЛД НИСЭХ
БОЛОМЖТОЙ БОЛЛОО




Манай улстай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулсан 40 орны хувьд дэлхийн хэмжээний томоохон агаарын тээвэрлэгчид нислэг гүйцэтгэх боломж бүрэн нээлттэй.

Тухайлбал, АНЭУ-ын 4, Сингапурын 6, ОХУ-аас 9 тээвэрлэгч, Солонгосын 6 гээд 16 улсын 47 тээвэрлэгч Монгол Улсын нутаг дэвсгэрт хуваарьт нислэг гүйцэтгэхээр томилогдсон, Монголын талаас 5 агаарын тээвэрлэгч 19 улсын 42 хотын чиглэлд нислэг гүйцэтгэх боломжтой байгаа. Монгол Улсын агаарын тээврийн зорчигч урсгалын зах зээлийг “бойжуулна” гэж ярьдаг. Энэ ажлыг “МИАТ” ТӨХК бойжуулж, босгож ирсэн. Эрхүү, Улаан-Үүд, Хөх хот, Москва, Бээжин, Сөүл, Истанбул, Хонг Конг, Берлин, Франкфурт, Токио, Осакао, Алма-Ата, Бусан, Бангкок гээд 20 гаруй чиглэлд нислэг эхлүүлж, нээсэн. Хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгчид маань сүүлийн 10 гаруй жилд шинээр Манжуур,

Хайлаар, Харбин, Эрээн, Будапешт, Астана, Бишкек, Парис гээд нислэгийн чиглэл нээсэн. Цаашид энэ чиглэлийн нислэгүүд улам тогтворжоод өргөжөөд явах төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласан. Үүнтэй холбогдуулан олон улсын нислэгийн чиглэл, давтамжийг нэмэгдүүлэх, орон нутгийн нислэгээ нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дотоодын нислэгийг сэргээж, жуулчдын аюулгүй, тав, тухтай байдлыг ханган зорчигч урсгалыг татах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Ойрын үед Грек, Унгар, Их Британи улстай шууд нислэг үйлдэх агаарын харилцааны хэлэлцээр байгуулах зорилт тавьж байна. Эдгээр хэлэлцээрүүдийг байгуулснаар дэлхийн гол агаарын тээврийн зангилаа цэгүүд рүү ямар нэг хязгаарлалтгүй, чөлөөтэй, шууд нисэх боломж бүрдэх юм.

АГААРЫН
ТЭЭВЭР



ТООН
МЭДЭЭЛЭЛ

ЭНЭ ОНД ОЛОН
УЛСЫН НИСЛЭГЭЭР

495

МЯНГАН ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭСЭН НЬ
2022 ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

+216

ХУВИАР ӨССӨН
БАЙНА.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД С.БЯМБАЦОГТ :

2023 ОНД 10 ОРЧИМ УЛСТАЙ АГААРЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛЭЛЦЭЭР
БАЙГУУЛНА

АГААРЫН ТЭЭВРИЙН ЛИБЕРАЛЧЛАЛД ШИНЭ ТҮРЛЭГ НЭМЛЭЭ


“МИАТ” ТӨХК “ТУРКИШ ЭЙРЛАЙНС” КОМПАНИТАЙ АЯЛЛЫН ДУГААР ХАМТРАН ЭЗЭМШИХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА



“МИАТ” ТӨХК болон “Туркиш Эйрлайнс” компаниуд зорчигчдынхоо аялах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор аяллын дугаар хамтран эзэмших гэрээ байгуулан ажиллаж эхэллээ. Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ компани болон “Star Alliance”-ийн гишүүн Туркиш Эйрлайнс компаниуд ийнхүү хамтран ажилласнаар зорчигч үйлчлүүлэгчдэдээ Монгол, Турк болон бусад улс орнуудын хооронд илүү уян хатан сонголттойгоор аялах боломжийг бүрдүүлж чадлаа.

“Туркиш Эйрлайнс” ньдэлхийн иргэний агаарын тээврийн салбарт өргөн сүлжээтэй, томоохон компаниудын нэг бөгөөд тус компаниатай Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК хамтран ажиллах болсон нь компанийн нислэгийн сүлжээг өргөжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулах юм.





МОНГОЛ УЛС, КАТАР УЛСТАЙ АГААРЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛЭЛЦЭЭР ҮЗЭГЛЭЛЭЭ


Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгчид 2023 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Катар Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын ерөнхийлөгч Мухамед Фале Ал Хажритай уулзаж, агаарын харилцааны асуудлаар санал солилцож, хоёр улсын үндэсний агаарын тээвэрлэгчдийг томилсон “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. “МИАТ” ТӨХК Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/22 тушаалаар Улаанбаатар-Доха чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилогдсон.

Мөн уулзалтаар хоёр улс хоорондын агаарын тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар ярилцлаа. Монгол Улс, Катар Улсын Иргэний нисэхийн байгууллагууд 2014 онд Агаарын харилцааны тухай хэлэлцээрийн төслийг тохирч үзэглэсэн бөгөөд уг хэлэлцээрийг ойрын хугацаанд эцэслэн байгуулахаар тохирлоо. Уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор хоёр улсын агаарын тээвэрлэгчид шууд болон коммерын хамтын ажиллагааны хүрээнд нислэг үйлдэх боломж бүрдэнэ.



МОНГОЛ УЛС БОЛОН КУВЕЙТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД АГААРЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛЭЛЦЭЭР ҮЗЭГЛЭЛЭЭ

Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгчид 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Кувейт Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга Эмад Ал-Желви тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, хоёр улсын агаарын тээврийн салбарын хамтын ажиллагаа, агаарын харилцааны асуудлаар санал солилцож, Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрийг үзэглэлээ. Уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор хоёр улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчид шууд болон коммерын хамтын ажиллагааны хүрээнд нислэг үйлдэх боломж бүрдлээ.



Кувейт Улсын Засгийн газар 139 улсын Засгийн газартай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулжээ. Кувейт Улсын агаарын тээврийн салбар Ковид-19 цар тахлын өмнө 2019 онд 16 сая зорчигч тээвэрлэж байсан бол 2022 онд 11 сая зорчигч тээвэрлэсэн байна. Тус улс нисэх буудлын хүчин чадлаа сайжруулах зорилгоор 25-30 сая зорчигч хүлээн авах хүчин чадал бүхий шинэ зорчигч үйлчилгээний терминал 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.



2023 ОНД НЭГ САЯ 500 МЯНГАН ЗОРЧИГЧ АГААРААР ТЭЭВЭРЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ

БНСУ-Монгол Улс хоорондын нислэгийн давтамж 7 хоногт 44 байсныг 80 хүртэлх нислэг болгож нэмэгдүүлжээ. Өөрөөр хэлбэл өдөртөө 11 нислэг хийгдэх боломж бүрдлээ. Мөн дараах чиглэлд нислэгийн тоо, давтамжуудыг нэмэгдүүллээ.

- Япон Улсын чиглэлд нислэгийн давтамж 7 хоногт 26 байсныг 62 болгож;
- Тайландын чиглэлд 7 хоногт 10 байсныг 30 болгож;
- Монгол-Туркийн чиглэлд 7 хоногт 6 байсныг 34 болгож;
- УБ-Бээжингийн чиглэлд 7 хоногт 42 удаа нислэг үйлдэх боломжийг бүрдүүллээ.
- Мөн Катар, Кувейт улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулах эрхийг олголоо. Ингэснээр Ойрхи дорнод, баруун азийн орнууд руу шууд нислэгтэй болж, экспортын ачааны эргэлт нэмэгдэж, аялал жуулчлалыг хөгжүүлэх өндөр ач холбогдолтой юм.
- Энэ ондоо багтаж АНУ-тай "OPEN SKY" хэлэлцээрт гарын үсэг зурснаар

хоёр улсын авиа компаниуд Монгол-Америкийн хооронд дурын хот руу шууд нислэг үйлдэх боломж бүрдэнэ.

- 2023 онд Австрали Улстай "OPEN SKY" хэлэлцээр хийнэ.
- Мөн энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөт хэлэлцээрүүдэд ГРЕК, УНГАР, ИХ БРИТАНИ зэрэг улсуудтай шууд нислэг үйлдэх агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

Эдгээр хэлэлцээрүүдийг байгуулснаар дэлхийн гол агаарын тээврийн зангилаа цэгүүд рүү ямар нэг хязгаарлалтгүй, чөлөөтэй, шууд нисэх боломж бүрдэнэ.

- Нислэгийн томилгоог авиа компаниуд хоорондоо зөвшилцөж, салбарын сайд түүнийг нь зөвхөн батламжилдаг болсноор тэгш боломж, чөлөөт өрсөлдөөнийг бий болголоо.

АНУ РУУ ШУУД, ХЯМД НИСЭХЭД НЭГ АЛХАМ ОЙРТЛОО

АНУ-тай Агаарын харилцааны хэлэлцээр байгуулснаар Open Sky буюу тус улсын дурын чиглэлд 2024 онд шууд нисэх боломж бүрдэнэ.

Энэ хүрээнд МИАТ ТӨХК шууд нислэг үйлдэх зорилгоор БИОНГ 787-900 онгоцыг хүлээн авахаар бэлтгэл ажил хангаж байна. Эхний онгоц нь 2023 оны наймдугаар сарын сүүлээр, дараачийнхийг 2024 оны эхний улиралд багтаан авчирна. Ингэснээр АНУ-руу шууд нислэг үйлдэх бүрэн боломжтой болно.



АГААРЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ҮЗЭГЛЭЛЭЭ



Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгчид 2023 оны нэгдүгээр сарын 24-ний өдөр АНУ-ын Төрийн департаментын Тээврийн асуудал хариуцсан газрын нарийн бичгийн дарга Ричард Ёнеока тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, санал солилцлоо. Талууд уулзалтаар Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хооронд байгуулах Агаарын

тээврийн тухай хэлэлцээрийг үзэглэж, санамж бичигт гарын үсэг зурлаа.

Ингэснээр, Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан агаарын тээврийн либералчлал, хямд тийз-хүртээмжтэй нислэгтэй болох зорилт нэг алхмаар урагшиллаа.

Энэхүү хэлэлцээр нь Монгол Улс-АНУ хооронд байгуулах агаарын тээврийн салбарын анхны хоёр талт хэлэлцээр бөгөөд, АНУ-ын “Нээлттэй тэнгэр” бодлогод нийцсэн нислэгийн багтаамж, давтамж, дурын чиглэлд нислэг үйлдэх, агаарын тээвэрлэгчид аяллын дугаар хамтран ашиглах боломжтой либерал хэлэлцээр юм.

Уг агаарын тээврийн хэлэлцээр байгуулснаар манай хоёр улсын эдийн засаг, худалдааны эргэлтийг сайжруулах, агаарын тээвэрлэгчид, аялал жуулчлалын компаниудад шинэ боломжуудыг бий болгох бөгөөд зорчигч, жуулчид хоёр улсын хооронд богино хугацаанд хямд үнээр ая тухтай зорчих боломж бүрдэх юм байна.



БНСУ-РУУ ҮЙЛДЭХ ШУУД НИСЛЭГИЙН ДАВТАМЖ, СУУДЛЫН БАГТААМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, 7 ХОНОГТ 70 ХҮРТЭЛХ НИСЛЭГ ҮЙЛДДЭГ БОЛЛОО

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны хоёрдугаар сарын 13-ны өдрийн А/39 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд 1991 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Хоёр орны нутаг дэвсгэрт болон тэдгээрийн чанадад агаарын харилцаа тогтоох тухай хэлэлцээр”-ийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсэг Улаанбаатар хотноо 2023 оны хоёрдугаар сарын 16, 17-ны өдөр ажиллан БНСУ-ын талтай агаарын харилцааны уулзалт, хэлэлцээ хийж, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.



ТУС ХЭЛЭЛЦЭЭРИЙН ҮР ДҮНД:

Нислэгийн давтамж, багтаамж нэмэх чиглэлээр:

Улаанбаатар-Сөүл чиглэлд нислэгийн давтамж, багтаамжийг нэмэгдүүлж, өвлийн улиралд БНСУ-ын талаас долоо хоногт 2,500 суудлын багтаамжтай 9 давтамжийг 3,350 багтаамжтай 12 удаагийн давтамжтай,

Монгол Улсын талаас долоо хоногт 2,500 суудлын багтаамжтай 11 давтамжийг 3,350 багтаамжтай 15 удаагийн давтамжтай,



зуны улиралд БНСУ-ын талаас долоо хоногт 5,000 суудлын багтаамжтай 18 давтамжийг 6,000 багтаамжтай 22 удаагийн давтамжтай, Монгол Улсын талаас долоо хоногт 5,000 багтаамжтай 20 давтамжийг 6,000 багтаамжтай 27 удаагийн давтамжтай нислэг үйлдэхээр тохиролцсон.

Мөн Улаанбаатар-Бусан чиглэлд давтамж, багтаамжийг нэмж долоо хоногт 585 суудлын багтаамжтай 3 давтамжийг 1,200 суудлын багтаамжтай 6 удаагийн давтамжтай нислэг

үйлдэхээр тохиролцон суудлын багтаамж болон давтамжийг нэмэгдүүллээ.

Мөн МУ-ын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг эдийн засгийг дэмжих салбар болгох зорилго тавин ажиллаж байгаатай холбогдуулан орон нутгийн Ховд, Даланзадгад, Чойбалсан хотуудыг агаарын харилцааны хэлэлцээрт цэгээр нэмж тохирох саналыг танилцуулж, харилцан шинэ 3 чиглэл нээх зарчмаар хамтран ажиллахаар боллоо.

ТОВЧ МЭДЭЭ

АГААРЫН ХӨЛГИЙН ЭНТЕРТАЙМЕНТ СИСТЕМИЙГ ШИНЭЧИЛЛЭЭ

МИАТ ТӨХК зорчигч үйлчлүүлэгчиддээ тав тухыг эрхэмлэн видео контент үзэх боломж бүхий EverHub төхөөрөмжийг агаарын хөлгүүдэд суурилууллаа. Уг төхөөрөмжийн тусламжтай зорчигч Та бүхэн дэлхийн шилдэг кино, монгол сонгодог кино, ТВ шоу, контент, энтертаймент нэвтрүүлгүүдээс сонгон өөрийн гар утас, таблет, зөөврийн компьютер ашиглан үзэх боломжтой.

В767-300 ER АГААРЫН ХӨЛГИЙГ НОЙТОН ТҮРЭЭСИЙН ЗАРЧМААР ТҮРЭЭСЛЭЛЭЭ

Аялал жуулчлалын оргил үе, зуны нислэгийн үеэр ХБНГУ-ын Франкфурт, БНТУ-ын Истанбул хот руу аялж буй зорчигчдод ая тухтай, шуурхай үйлчлэх зорилгоор В767-300 ER агаарын хөлгийг Omni Air International компаниас нойтон түрээсийн зарчмаар түрээслэн авч нислэг үйлдвэрлэлдээ ашиглаж эхэлсэн.

УЛААНБААТАРААС ОЙРХИ ДОРНОД, ХОЙД АФРИК, БУЛАНГИЙН ОРНУУД РУУ ХУРДАН ШУУРХАЙ ЗОРЧИГЧ, АЧАА ТЭЭВЭРЛЭХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ



Энэ оны гуравдугаар сард Монгол, Катарын хооронд шууд нислэг үйлдэх хоёр Улсын Засгийн газар хоорондын Агаарын тээврийн хэлэлцээрт талууд гарын үсэг зурсан бөгөөд 2023 оны дөрөвдүгээр сарын 26-ны тус “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар эцэслэн баталлаа. Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор хоёр улсын агаарын тээвэрлэгч компаниуд шууд болон коммерын хамтын ажиллагааны хүрээнд нислэг үйлдэж, аялал жуулчлал, бизнес, худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжих өргөн боломж бий болж байна.





ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДЛАА

Иргэний нисэхийн тухай хуулийг 1999 онд баталж байсан бөгөөд 24 жилийн дараа уг хуулийг бүрэн шинэчиллээ.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

Хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, зах зээлийн шударга өрсөлдөөнийг бий болгох, агаарын тээврийн тогтвортой байдлыг хангах, нийтэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлнэ.

- Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- Монгол Улсын иргэний нисэхийн эрх зүйн зохицуулалт олон улсын хэм хэмжээнд нийцэж, салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ
- Иргэний нисэхийн аюулгүй байдал сайжирна.
- Шинжлэн шалгах ажиллагааны бие даасан,

хараат бус байдал хангагдсанаар нислэгийн осол, зөрчил гарах нөхцөлийг бууруулна.

- Нислэгийн үйл ажиллагаа, түүнд дэмжлэг үзүүлэх агаарын навигаци, аэродром, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний чиг үүрэг тодорхой болно.
- Улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг болохуйц иргэний нисэхийн дэд бүтэц, агаарын тээврийн тогтолцоо бүрдэнэ.

Ингэснээр бие даасан үйл ажиллагаа явуулах, орон тооны давхардлыг арилгах, хөрөнгө оруулалтын үр ашиг нэмэгдэх боломжтой болж байна.



ТАЛЫН МОНГОЛООС ТРАНЗИТ МОНГОЛ

“ХӨГЖЛИЙН СУДАС-ТӨМӨР ЗАМ”

Манай экспортын томоохон сорилт бол дэд бүтэц тэр дундаа олон жил яригдаж буй төмөр зам юм. Хилийн боомтуудыг төмөр замаар холбох нь далайд гарцгүй манай улсын хувьд стратегийн чухал ач холбогдолтой. Тэгвэл удаан хүлээсэн төмөр замууд эхнээсээ ашиглалтад орж, зам тээврийн салбарт шинэ сэргэлт айсуу. Стратегийн чухал ач холбогдолтой, шинэ төмөр замын төслүүдийг амжилттай дуусгахаар шаргуу ажилласаар байна.

Тодруулбал, Эдийн засгийн ач холбогдлоороо өндрөөр үнэлэгдэх нүүрсний экспортын гол боомтын нэг Шивээхүрэн Орос-Монгол-Хятад гурван улсын гол коридор болох цаг удахгүй аж. Учир нь Шивээхүрэн -Сэхээ хилийн боомтыг холбосон нарийн царигтай төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны тавдугаар сард эхлүүллээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын Боомтын сэргэлт зорилтын хүрээнд хилийн 14 боомтыг хатуу хучилттай авто зам, төмөр замаар холбож, боомтуудын дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх зорилт бодит ажил болж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд Монголын төмөр зам ТӨХК Шивээхүрэн боомтыг Хятадын Сэхээ боомттой 7,1 км төмөр замаар холбох бүтээн байгуулалтын ажлыг эхлүүллээ. Шивээхүрэн боомт нь нүүрсний экспортын 48 хувийг гаргадаг стратегийн ач холбогдолтой боомт юм. Ирэх аравдугаар сард энэ боомт ашиглалтад орж, нүүрс тээвэрлэлт эхэлнэ.



**ГАНЦМӨД БООМДЫН ХИЛ
ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН ХОЁР ТАЛЫН
ХАРИУЦАХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ
2023 ОНД БАГТААН ЭХЛҮҮЛНЭ**



Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Чайна энерги” группийн ТУЗ-ийн дарга Лю Гүеюэ нар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр нэгдсэн байр суурьт хүрлээ. “Чайна энерги” группийн ТУЗ-ийн дарга Лю Гүеюэ онцлон тэмдэглэхдээ, тус групп цаашид Монгол Улстай тогтвортой бөгөөд урт хугацааны хамтын ажиллагаа хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа нотоллоо. Уулзалтын эхэнд, Монгол Улсын Гашуунсухайт боомт болон БНХАУ-ын Ганцмод боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг цаг алдалгүй эхлүүлэх талаар илэн далангүй ярилцлаа.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Чянтай хийх албан ёсны хэлэлцээний өмнө “Чайна энерги” группийн удирдлагуудтай уулзалт хийж, олон жил яригдсан бүтээн байгуулалтын төслийн талаар санал солилцож, зарчмын тохиролцоонд хүрсэн нь онцлог байлаа.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2022 оны хоёрдугаар сард БНХАУ-д хийсэн ажлын айлчлалын хүрээнд 10 гаруй жил гацаанд орсон Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын цэгийг харилцан тохиролцсон билээ.

Энэ удаагийн уулзалтын үеэр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын хоёр талын хариуцах бүтээн байгуулалтыг 2023 онд багтаан эхлүүлж, 2024 онд ашиглалтад оруулах зорилт дэвшүүлэхээр харилцан тохиролцлоо. “Чайна энерги” группийн ТУЗ-ийн дарга Лю Гүеюэ онцлон тэмдэглэхдээ, тус групп цаашид Монгол Улстай тогтвортой бөгөөд урт хугацааны хамтын ажиллагаа хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа нотоллоо.

БООМТЫН СЭРГЭЛТ – ТӨМӨР ЗАМ

5600 ОРЧИМ
ҮНДЭСНИЙ
төмөр замын
сүлжээ

30 сая тонн
50-75 САЯ ТОННД
ачааны хэмжээг хүргэнэ



ИДЭВХТЭЙ
АЖИЛЛАГААТАЙ
БООМТУУДЫН
ТООГ
НЭМЭГДҮҮЛЭХ

“ БООМТЫН СЭРГЭЛТ ”

НЬ МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

-Монгол Улс 2019 онд 35 сая тонн нүүрс урд хөршийн зах зээлд экспортолсон нь түүхэн дээд амжилт байв. Тэгвэл экспортын төмөр замууд бүрэн хүчин чадлаар ажиллаж эхэлснээр нэг жилд 30 сая тонн нүүр хилээр гаргах бололцоо бүрдэнэ. Тээврийн салбарын сэргэлт нь тээврийн зардлыг бууруулснаар Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, экспорт, эдийн засагт өсөлт дагуулах хөгжлийн хөшүүргийн үүргийг гүйцэтгэх юм-

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийг хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлж, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлох, өөрчлөх зорилго бүхий дунд хугацааны хөтөлбөр юм. Үндсэн зургаан чиглэлд зорилгоо төвлөрүүлж байгаагийн нэг нь хилийн боомтуудыг хөгжүүлэх “Боомтын сэргэлт”-ийн бодлого. Энэ нь зөвхөн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай бус тээвэр, ложистикийг бэрхшээлийг шийдвэрлэх бодлого гэж Засгийн газар үзэж буй юм.

Дэлхий дахин, бүс нутгийн хөгжлийн хурд, өнөө цагийн эрэлт хэрэгцээг гүйцэлдүүлэхэд хүчин мөхөстөж байгаа тээвэр ложистик, үүнээс үүдэлтэй тээврийн зардал нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг хойш татаж буй нэг үзүүлэлт. Далайд гарцгүй орнуудын хувьд тээврийн зардал бараа, бүтээгдэхүүний өртгийн 10 хүрэхгүй хувь гэж үздэг бол манай улсад нөхцөл байдал арай өөр.

Монголоос хамгийн ойр далайн боомт хүртэл 1700 км байгаа бол Казахстаны Алма-Ата хотоос хамгийн дөт боомт хүрэх зам 3380 км ч тээврийн зардал нь манайхаас хоёр дахин бага байгаа юм. Туулах замын урт хоёр дахин урт гэсэн үг. Казахстанд тээврийн зардал нь тонн тутамд 37 цент байгаа бол Монголд

импорт нь 87 цент, экспорт нь 61 центийн зардалтай байна. Тэгэхээр экспорт, импортын орц, гарц болох боомтууд, экспортын төмөр зам, тээвэр ложистикийг сайжруулахгүйгээр өрсөлдөх чадварын талаар ярих боломжгүй. Боомтын сэргэлтийн хүрээнд ашиглалтад оруулсан экспортын өндөр ач холбогдол бүхий Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замууд нь стратегийн гол орд болох Тавантолгойн ордын нүүрсийг Хятадын хилийн боомт хүргэх зорилготой.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь 2022 оны есдүгээр сард албан ёсоор нээлтээ хийсэн. Замын урт 233.6 километр үргэлжлэх бөгөөд жилд дунджаар 236 сая ам.долларын орлоготой, 147 сая ам.долларын ашигтай ажиллах тооцоотой.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн зам 416.1 км урттай. Жилд 15 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай. Эдгээр төмөр замууд Замын-Үүд боомтын төвлөрлийн 70 хувийг Бичигт боомт болон Гашуунсухайт боомт руу шилжүүлнэ.

Монголын уул уурхайн экспорт нийт экспортын 90 орчим хувийг эзэлж буй. Үүнд нүүрс зонхилох нөлөөтэй. Монгол Улс 2019 онд 35 сая тонн нүүрс урд хөршийн зах зээлд экспортолсон нь түүхэн дээд амжилт байв. Харин дээрх төмөр замууд ашиглалтад орсноор нэг замаар жилд 30 сая тонн нүүр хилээр гаргах бололцоо бүрдэнэ гэж тооцоолж байна.

Өнгөрсөн оны 11 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан төмөр зам нь Зүүнбаянгаас Ханги-Мандалын боомт хүрэх төмөр зам байх юм. Ханги-Мандалын боомт нь БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Бугат хоттой хамгийн ойр боомт. Бугат хотын гангийн үйлдвэр нь Монголын төмрийн хүдэр болон коскжих нүүрсний дийлэнхийг худалдан авдаг. Тийм учраас Замын-Үүд боомтоос Бугат хот хүртэлх экспортын тээвэр эцсийн худалдан авагч руугаа дөт замаар хүрэх бололцоог Зүүнбаян-Ханги



Мандалын төмөр зам бүрдүүлнэ.

Монгол Улс өнөөдрийг хүртэл уул уурхайн экспортдоо автотээврийг ашиглаж ирсэн нь экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг хааснаас гадна хилийн хорио цээрийн дэглэмийн үед боомтуудын хүчин чадлыг хүндрүүлэн гацаа үүсгэж байлаа. Монголын нүүрсний экспорт 2021 онд олон хүчин зүйлээс шалтаалан ердөө 16 сая тонн болж буурсан юм. Энэ нь түүхэн дээд хэмжээнээс хоёр дахин бага байгаа хэрэг.

Дээр яригдаж буй экспортын ач холбогдол бүхий боомтууд нь худалдан авагчтай хамгийн ойр байрлалд байгаа төдийгүй олон жилийн турш үйл ажиллагаа явуулж ирсэн боомтууд юм. Харин шинээр тавигдаж байгаа төмөр замууд нь экспортын түүхий эдийн нөөцтэй тэдгээр боомтыг холбох хамгийн дөт замууд. Мөн хилийн боомтуудыг төмөр замаар холбох нь далайд гарцгүй орны хувьд стратегийн чухал бодлого юм. Тэгвэл удаан хүлээсэн төмөр замууд ашиглалтад орсноор тээвэр, ложистикийн салбарт шинэ сэргэлт бий болно. Энэхүү сэргэлт нь экспорт, эдийн засагт өсөлт дагуулах хөгжлийн хөшүүрэг, хөдөлгөгч хүч болох юм.

Тодруулбал, нүүрсний экспортын гол боомтын нэг Шивээхүрэн-Сэхээ нь Орос-Монгол-Хятад гурван улсын төмөр замын коридор болох газар зүй- эдийн засгийн нөхцөл нэгэнт бүрдээд буй юм. Учир нь Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтыг холбосон нарийн царигтай төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2023 оны тавдугаар сард эхлүүлээ. Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Боомтын сэргэлт" зорилтын хүрээнд хилийн 14 боомтыг хатуу хучилттай авто зам болон төмөр замаар холбож, боомтуудын дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх зорилт бодит алхам болж байгаагийн эхлэл нь энэ юм.

Шивээхүрэн-Сэхээ боомт нь нүүрсний экспортын 48 хувийг гаргадаг стратегийн чухал ач холбогдол бүхий боомт. Энэ оны 10 дугаар сард хил холболтын төмөр замыг ашиглалтад оруулснаар нүүрс тээвэрлэлт эхэлж, экспортын шинэ гарц нээгдэнэ.

БАРУУН, ЗҮҮН БОСОО ТЭНХЛЭГИЙН ТӨМӨР ЗАМ

ОРОС-МОНГОЛ-ХЯТАДЫГ ХОЛБОСОН ТӨМӨР ЗАМЫН ГУРВАН КОРИДОРТОЙ БОЛНО



ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ БООМТЫН ХИЛИЙН ТӨМӨР ЗАМ НЬ ГУРВАН УЛСЫГ ХОЛБОХ БАРУУН КОРИДОРЫН ЭХЛЭЛ БОЛНО

“ Орос-Монгол-Хятад гурван улсыг холбох баруун босоо чиглэлийн 1255 км төмөр замын бүтээн байгуулалтын эхлэл нь Шивээхүрэн-Сэхээ боомтын хил холболтын төмөр зам юм

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Шивээхүрэн боомтыг БНХАУ-ын Сэхээ боомттой холбох хил дамнасан замын төслийг хэрэгжүүлэх эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон. Энэ дагуу Шивээхүрэн-Сэхээ боомтыг 7.1 км төмөр замаар холбох замын суурь бүтэц барих зөвшөөрлийг “Нарийнсухайтын төмөр” ХХК-д олгосон бөгөөд уг замыг энэ оны 10 дугаар сард ашиглалтад хүлээлгэн өгөхөөр бүтээн байгуулалтын ажлыг тавдугаар сараас эхлүүлээд байна.

Шивээхүрэн-Сэхээ боомтын хил холболтын төмөр зам нь хэдий 7.1 км боловч энэ нь Орос-Монгол-Хятад гурван улсыг холбох баруун босоо чиглэлийн 1255 км төмөр замын бүтээн байгуулалтын эхлэл болж байгаагаараа ач холбогдолтой юм.



ГОЛ ТӨМӨР ЗАМЫН УРТ **7.7 КМ**
 ДЭЛГЭМЭЛ УРТ **19.3 КМ**
 1 ӨРТӨӨТЭЙ,
 2 ДУГААР
 ЗЭРЭГЛЭЛИЙН,
 НАРИЙН
 ЦАРИГТАЙ
 БАРИХААР
 ТӨЛӨВЛӨСӨН.



Шивээхүрэн-Сэхээ боомтоор сүүлийн таван жилийн хугацаанд 45 сая тонн нүүрсийг экспортод гаргасан байна. Монгол, Хятадын хилийн боомт болох Шивээхүрэн, Сэхээг төмөр замаар холбох бүтээн байгуулалтын ажил 2023 оны 10 дугаар сард бүрэн дуусахаар төлөвлөж буй.



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД С.БЯМБАЦОГТ :

Ирэх 15-30 жилд төмөр замын салбар нь улс орныхоо эдийн засгийг өөд татаж, босгож ирэх илүү хүчирхэг болгоход бодитой хувь нэмэр оруулна гэж төсөөлж байна.

ЧОЙБАЛСАН-ХӨӨТ-БИЧИГТ ЧИГЛЭЛ НЬ ГУРВАН УЛСЫГ ХОЛБОХ ЗҮҮН БОСОО ТЭНХЛЭГИЙН ЗАМ БОЛНО



Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хамтран эзэмшдэг босоо тэнхлэгийн гол төмөр зам бол Орос-Монгол-Хятад гурван улсаар дамжуулан Евро-Азийг холбосон чухал коридор. Тэгвэл дараагийн ээлжинд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд зүүн коридорын төмөр замыг байгуулахаар төлөвлөсөн юм. Энэ нь Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам юм. ОХУ-аас Дорнод аймгийн төв Чойбалсан хот хүртэлх 240 км төмөр замыг социализмын үед байгуулсан бөгөөд өдгөө энэ замыг урагшаа Хятадын хил хүртэл холбосноор Орос, Монгол, Хятадыг холбосон зүүн коридорын зам бий болно. ОХУ-аас Чойбалсан хүртэл 240 км замыг үргэлжлүүлэн Хөөт зангилаа хүртэлх 193 км, Хөөт өртөөнөөс Бичигтийн боомт хүртэлх 220 км замыг нэмж тавьснаар нийт 600 км төмөр замаар гурван улс холбогдоно. Энэхүү шинэ трассыг дагасан зүүн бүс нутаг нь ашигт малтмалын асар их нөөцтэй юм. Уг нөөцийг ашиглахгүй өнөөдрийг хүрсэн нь дэд бүтэц

бүрдээгүйтэй холбоотой. Харин дээрх төмөр зам баригдсанаар уул уурхайн түүхий эдийг хямд зардлаар хилийн боомт буюу өмнөд зах зээлд хүргэх боломж бүрдэнэ. Өнөөдөр Өмнөговь аймагт уул уурхай эрчимтэй хөгжиж, тус аймаг ДНБ-ий хэмжээгээр улсдаа тэргүүлдэг болсон гол хүчин зүйл нь нэгдүгээрт дэд бүтэц хөгжсөнтэй, хоёрдугаарт, хилийн боомттой ойр байрлалд байгаа явдал юм.

Монгол Улс өнөөдрийг хүртэл уул уурхайн экспортдоо автотээврийг ашиглаж ирсэн нь байгаль орчны сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж, экспортоо зорилтот түвшинд хүргэхэд хангалтгүй байна. Түүнчлэн цар тахал, хилийн хорио цээрийн дэглэмийн гацаа үүсгэж байлаа. Монголын нүүрсний экспорт 2021 онд олон хүчин зүйлээс шалтаалан ердөө 16 сая тонн болж буурсан юм. Энэ нь түүхэн дээд хэмжээнээс хоёр дахин бага байгаа хэрэг.

Хил холболт, боомтын төмөр замыг барьж эхлүүлснээр баруун, зүүн, гол тэнхлэгийн гэсэн үндсэн гурван коридороор Орос-Монгол-Хятадыг холбох ажил эрчимжиж, транзит тээврийн орлого нэмэгдэх нь эдийн засгийн үр өгөөжийн нэг хэсэг юм. Мөн 13 мянган байнгын ажлын байр, 20-30 мянган түр ажлын байр бий болж, төмөр зам дагасан нутагт бэлчээр сүйдэх, тоосжилт, дуу чимээ, хөрсний болон агаарын бохирдол буурах зэрэг нийгмийн өгөөжүүдийг ч бий болгоно. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-д энэ оны зургадугаар сард айлчлах үеэрээ зүүн босоо тэнхлэгийн буюу Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэснээ мэдэгдээд байна.



2023 ОНД ТӨМӨР ЗАМЫН ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛЫН АЖИЛ ЭХЭЛЛЭЭ



“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьд 2023 онд 5 сая тонн ачаа тээвэрлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаар 2023 онд экспортын нүүрс тээврийн хэмжээг нэмэгдүүлэхээр Эрдэнэс тавантолгой ХХК-тай харилцан тохиролцож, гэрээ байгуулсан.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замд Монголын Транс Ложистик ХХК-тай Тавантолгой-Цогтцэций чиглэлд “Суурь бүтэц ашиглуулах, тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх” гэрээг үзэглэж, 1-1.5 сая тонн ачаа тээвэрлэх урьдчилсан төлөвтэй байна.

Шилжүүлэн ачих терминал нь Тавантолгойн бүлэг ордоос төмөр замын тээврээр ачигдсан чингэлэгтэй ачааг вагоноос автомашинд

шилжүүлэн ачих, талбайд хадгалах, экспортын тээвэртэй холбоотой бичиг баримтын бүрдүүлэлт, төлбөр тооцоог хийх нэг цэгийн үйлчилгээ бүхий 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай байгууламж юм.

Тавантолгойгоос Гашуунсухайт чиглэлд төмөр замаар тээвэрлэсэн ачааг автотээвэрт шилжүүлэн ачиж чингэлэгт тээврийн терминалаар дамжуулан Гашуунсухайт боомтоор гаргах экспортын тээврийг гүйцэтгэнэ. ШАТ-чингэлгийн терминал, чингэлгийн терминал-ШАТ хүртэл нийт 4.8 км сайжруулсан авто зам барина.

Чингэлгийн талбайн хүчин чадал

1 талбайтай үед

12.4 СЯА.ТН

2 талбайтай үед

24.9 СЯА.ТН

Ашиглалтанд орсноор 167 ажлын байр бий болно. Уг терминалын барилга угсралтын ажил 2022-04-22-ны өдөр эхлээд газар шорооны ажил 100%, дөрвөлжин хоолойн

ажил 100%, дугуй хоолойн ажил 100%, дээд бүтцийн ажил 99,43%-тай явагдаж байна. 2023 онд барилга, байгууламж бүрэн ашиглалтад орно.



Монгол Улсын эдийн засгийг тэлж, шинэ эргэлтийг бий болгох “Тавантолгой төмөр зам”ХХК нь 2018 оны наймдугаар сарын 08-ны өдөр үүсгэн байгуулагдаж, төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, тээвэрлэх, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн засварлах зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЛЭЭ

Монгол Улсын “Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна энержи интернэшнл” ХХК, “Баошен төмөр зам” ХХК нарын хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх зорилготой санамж бичгийн төслийг хэлэлцэн, тохиролцсоноор 2023.02.11-ний өдөр хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулав



УГ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАГДСАНААР

Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо хооронд байгуулсан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”, “Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр”-ийн холбогдох шаардлагуудыг хэрэгжүүлэх бүрэн боломж бүрдсэн. Хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын явц нийт 15 хувийн гүйцэтгэлтэй, гэрээний дагуу төслийн техник, эдийн засгийн үндэслэл, иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлыг 2023 онд багтаан дуусгаж, барилга угсралтын ажлыг 2024 оны 03 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөж байна.

ТАВАНТОЛГОЙ-ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛД МОНГОЛЫН АНХНЫ ХҮНД ДААЦЫН ТӨМӨР ЗАМ АШИГЛАЛТАД ОРЛОО



Энэхүү төмөр зам нь Тавантолгой уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэл 233.6 километр үргэлжлэх гол замтай, нийт дэлгэмэл урт 321.6 километр, 2 өртөө (Тавантолгой, Гашуунсухайт), 6 зөрлөг (Хайрхан, Хангай, Уртгол, Оюут, Шинэ-Ус, Хулант), 16 гүүртэй, төмөр замын голын даац 25 тонн, царигийн хэмжээ 1520 мм юм.

Уг төмөр зам баригдсанаар манай улс жилдээ



30-50 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг тээвэрлэн экспортлох, улсын төсөвт жилд дунджаар 44 сая ам.долларын татвар төвлөрүүлэх, БНХАУ руу экспортлох нүүрс тээврийн өртөг Тавантолгой уурхайгаас Ганцмод боомт хүртэл 47 ам.доллаароос 12 ам.доллар болж, тонн тутамд 4 дахин буурах, 2000 орчим тогтмол ажлын байр нэмэгдэх урьдчилсан тооцоо гарчээ.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор төмөр замаар дамжуулах нүүрс, зэсийн экспортыг дэмжиж, БНХАУ-ын нутаг руу тээвэрлэх, цаашлаад тус улсын Тяньжин зэрэг далайн боомтуудаар дамжин гуравдагч орон руу тээвэрлэлт хийх, Монгол Улсын уул уурхайн компаниуд дэлхийн зах зээлд хямд үнээр өрсөлдөх боломж бүрдэж байна.



ТӨМӨР ЗАМААР ХИЙХ ЭКСПОРТЫН ХОЁР БОЛОН ГУРАВ ДАХЬ ГАРЦТАЙ БОЛЛОО

Төмөр замын салбарт Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 876.4 км төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил дуусаж, төмөр замаар хийх экспортын хоёр болон гурав дахь гарцтай боллоо.

ТӨМӨР ЗАМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



-Малын бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдол багасна.



-Авто тээврийн осол, зөрчил буурч, хөдөлгөөний аюулгүй байдал дээшилнэ.



-Төмөр замаар дамжуулах нүүрс, зэсийн экспортыг дэмжиж, БНХАУ болон цаашлаад тус улсын далайн боомтоор дамжин гуравдагч орон руу тээвэрлэх, мөн Монгол Улсын уул уурхайн компаниуд дэлхийн зах зээлд хямд үнээр өрсөлдөх боломжтой болно.

ТАВАНТОЛГОЙ- ГАСУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВЛАА

Монгол Улсын анхны нэгдүгээр зэрэглэлийн, уулзваргүй, хүнд даацын, жилд 30-50 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км төмөр зам болон Ачилтын тойрог замыг байнгын ашиглалтад хүлээн авлаа.



ЭНЭ ТӨМӨР ЗАМ АШИГЛАЛТАД ОРСНООР:

30-50

Жилд 30-аас 50 сая тн ачаа тээвэрлэнэ

X2

Монгол улсын нүүрсний экспорт 2 дахин нэмэгдэнэ.

3-4

Экспортын нүүрс тээврийн өртөг 3-аас 4 дахин буурна.

2000

Шууд болон шууд бус 2000 ажлын байр бий болно.

74%

Байгаль орчин, экологид үзүүлж буй сөрөг нөлөөлөл 74 хувь буурна.



ТӨМӨР ЗАМЫН СЭРГЭЛТЭЭР ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ ШИНЭЧИЛЛЭЭ



Манай улсын үндэсний төмөр замын сүлжээний урт 2,964.9 км болж өргөжөөд байна. Өнгөрөгч онд л гэхэд Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 876.4 км төмөр зам баригдсан.

Энэ хэрээр төмөр замын салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо эрс өсч байна. Урьд нь төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч ганцхан байсан бол өдгөө суурь бүтэц эзэмшигч 4, тээвэрлэгч 4, суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч 250 орчим болж нэмэгдээд байна. Үүнтэй холбоотойгоор Төмөр замын салбарын эрх зүйн орчинг шинэчлэлээ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С.МЯНДАСМАА:



ТӨМӨР ЗАМЫН
ТЭЭВРИЙН ТУХАЙ
ХУУЛЬ 16 ЖИЛИЙН
ДАРАА ШИНЭЧЛЭГДЭН
БАТЛАГДЛАА



ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

• Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой суурь харилцаа илүү тодорхой, оновчтой болж, авлига ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсооно.

• Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчдын тэгш оролцоог хангана.

• Суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ сайжирч, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашиг нэмэгдэнэ.

• Төмөр замын ажилтны нийгмийн

баталгаа сайжирч, тогтвортой ажиллах нөхцөл боломж бүрдэнэ.

• Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хуулийн хийдэл, зөрчил давхардал арилж, зохицуулалтгүй байгаа зарим харилцаа тодорхой болно.

• Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн орчин илүү сайжирна. Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт техник технологи эзэмших, инновац нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах боломж бүрдэж, тээврийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” ХНН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД 16 САЯ ТОНН АЧАА ТЭЭВЭРЛЭЭД БАЙНА



Х.Хэрлэн УБТЗ ХНН-ийн дарга: Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн /УБТЗ ХНН/ эзэмшиж буй босоо тэнхлэгийн төмөр зам нь одоогоор Орос-Монгол-Хятад гурван улсыг


холбосон ганц коридор юм. Монгол Улсын хөгжлийн нэг гол судас болсон тус төмөр замаар жилд 30 гаруй сая тонн ачаа тээвэрлэдэг 2023 оны хагас жилийн байдлаар 16 сая тонн ачаа тээвэрлээд байгаа нь өмнөх оноос 25.4 хувиар илүү байна. Мөн 2023 оны эхний хагас жилд 1,1 сая зорчигч тээвэрлээд байгаа нь өмнөх оны мөн үеэс 5,9 хувиар илүү үзүүлэлттэй байна.

“Улаанбаатар төмөр зам” ХНН нь нийгмийн хариуцлагын хүрээнд олон жил алдагдалтай тээврийн тарифыг мөрдөж ирсэн бөгөөд хөдлөх бүрэлдэхүүний парк шинэчлэлт, замын их засвар хийх, үйлчилгээний чанараа сайжруулахад хүндрэл учруулж ирсэн. Үүнээс гадна дизелийн түлш, сэлбэг материалын дэлхийн зах зээл дээрх үнэ огцом өссөн. Эдгээр шалтгааны улмаас УБТЗ-ын тээврийн алдагдлыг бууруулах зорилгоор тарифын индексжүүлэлтийг хэрэгжүүлээд байна.

УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН ИХ ӨРИЙГ ТЭГЛЭЖ, ДҮРМИЙН САНГ 167 ТЭРБУМААР НЭМЭГДҮҮЛЛЭЭ

УИХ-ын дарга Г.Занданшатарын ОХУ-д 2023 оны зургаадугаар сард хийсэн айлчлалын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт ОХУ-ын Тээврийн сайд В.Савельевтай уулзаж, “Орос - Монголын хамтарсан Улаанбаатар төмөр зам”-ыг байгуулах тухай хэлэлцээрт нэмэлт протоколд гарын үсэг зурлаа. Протоколын

хүрээнд 2009 оноос хойш гацаад байсан МОН П1,П2 зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг дуусгавар болгон шийдвэрлэж, олон жил яригдсан асуудлуудад цэг тавьсан байна. Монгол Улс, ОХУ-ын хооронд үүсээд байсан томоохон асуудал шийдэгдэж, хоёр улсын хамтын аиллагааг өргөжүүлэхэд томоохон түлхэц боллоо.



ПРОТОКОЛ БАЙГУУЛСНААР

Улаанбаатар төмөр зам ХНН-ийн дүрмийн санг 167 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, хугацаа хэтэрсэн зээлгүй болж, парк шинэчлэлт, замын засвар, хөрөнгө оруулалт хийх эдийн засгийн чадвар эрс сайжирч, зээлжих эрх нь нэмэгдэж байна.

ОХУ-ын талаас дүрмийн санд нийлүүлж буй 5 зүтгүүрийг авснаар ачаа тээх хүчин чадал 2 сая. тонноор нэмэгдлээ. Ийнхүү экспортын болон транзит тээвэрт саад болж байсан зүтгүүрийн дутагдлаас гарлаа.



ОРОС-МОНГОЛ-ХЯТАДЫГ ХАМАРСАН ТЭЭВРИЙН КОРИДРООР 60 САЯ ТОНН АЧАА ТЭЭВЭРЛЭХИЙГ ЗОРИНО



Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, ОХУ-ын Тээврийн сайд В.Савельев нарын уулзалтаар яригдсан ажил, алс хэтийн зорилтуудыг бодитой болгох үүднээс “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн холбогдох албан тушаалтнуудад тодорхой үүрэг даалгаврыг өглөө.

- Орос-Монгол-Хятад гурван улсыг хамарсан тээврийн коридорыг хөгжүүлэх, тээвэрлэх ачааны хэмжээг 60 сая тоннд хүргэх,
- Эдийн засгийн коридорын хүрээнд Богдхан төмөр замын төслийг эхлүүлэх, Хөшигтийн хөндийн тээвэр ложистикийн төвийн гол төмөр замд холбох,
- Зүүн босоо тэнхлэгийн төмөр замын Эрээнцав-Чойбалсан хэсэглэлийн их засвар, шинэчлэлийн ажлыг эхлүүлэх,
- АН-3, АН-4 авто замаар явж буй транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж, хязгаарлалтуудыг багасгахаар цаашид ажиллахыг даалгалаа.

Улаанбаатар төмөр зам ХНН-ийн
Зорчигч тээврийн төвийн үйлчилгээ
хариуцсан менежер

Л.ДЭЛГЭРМАА:

“ МОНГОЛД
ЗОЧЛОХ ЖИЛИЙН
ХҮРЭЭНД
ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ
ТӨГС БОЛГОХ
ЗОРИЛТ ТАВЬСАН



-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт үзүүлэх шийдвэр хэрэгжиж эхэлсэн байсан?

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхээ шалгуулан, унтлагын вагоныг 20 хувь, тасалгаат вагоныг 30 хувиар хөнгөлүүлэн тасалбараа захиалах боломжтой. Одоогийн байдлаар цахимаар захиалах боломжгүй байгаа. Удахгүй цахимжуулна.

Тийзний хөнгөлөлт үзүүлэхээс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замаа зассан, тусгай тэмдэглэгээ бүхий зогсоолуудыг байршуулсан. Мөн галт тэрэг хүлээх явцдаа амрах байранд халуун хоол, кофе, цайгаар үйлчлүүлэх боломжтой.

-Зам, тээврийн хөгжлийн яам 2023 оныг Бүрэн цахимжсан жил болгон зарласан. Тасалбар цахимжуулалтын тухайд?

Иргэдэд чирэгдэл учруулахгүйгээр галт тэрэгний тасалбарыг хамгийн хүртээмжтэй, шуурхай, найдвартай байхаар шийдсэн. Үүнд, UBTZ аппликейшн, eticket.ubtz.mn цахим сайт, 1800-1959 гар утсаар, TAPATRIP гээд өөрт аль боломжит сувгаараа

цахимаар захиалах боломжтой.

-Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласан. Энэ хүрээнд төмөр замын салбар үйлчилгээний чанараа сайжруулахад хэрхэн анхаарч байна вэ?

-Улаанбаатар төмөр зам ХНН Монголд зочлох жилийн үйлчилгээгээ сайжруулахын тулд бүх үйлчилгээгээ иргэдэд ойртуулж, хүртээмжтэй, хялбар болгохоор ажиллаж байна. Мөн өмнөх үйлчилгээнүүдээ сайжруулах тал дээр дорвитой арга хэмжээ авч ажиллаж байгаа. Тухайлбал, галт тэрэгний чиглэл, цагийн хуваарь, тарифын самбаруудаа шинэчилсэн. Хүүхдийн өрөө, амралтын өрөө, вип өрөөнүүдээ шинээр тохижуулсан. Нэмэлтээр хөтөч болох газрын зураг байршуулаад байна.

Мөн бүх чиглэлд люкс вагон тогтмол аялуулж байна. Энгийн вагонтой харьцуулахад тарифын хувьд өндөр ч гэлээ эрэлт хэрэгцээ өндөр тасалбар нь маш хурдан борлуулагдаж байна. Иргэдээс люкс вагоноо нэмж өгөөч гэсэн хүсэлт ирсний дагуу завсар үйлчилгээ хийж, бэлтгэл ажлаа хангаж



байгаа. Мөн үйлчилгээгээ төгс болгох зорилт тавьж буфет хоолны кейтеринг үйлчилгээ, худалдаа, валют солих, найдвартай такси үйлчилгээ, зочид буудал, цэцэг захиалга, бэлэг дурсгалын зүйл худалдан авах зэрэг бүхий л үйлчилгээг зорчигчиддоо санал болгож, төрөлжүүлж байна. Олон улсын аль ч вагонд захиалгаа өгсөн такси, зочид буудлыг нь бэлдэх боломжтой болно. Мөн орон нутгийн иргэд ачаа, тээш ихтэй ирдэг. Ачаагаа шууд таксинд хүргүүлэх, хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэхээр UBCAB, тээш хүргэлтийн үйлчилгээтэй хамтран ажиллахаар бэлтгэл

ажил хангасан. Удахгүй нэвтрээд эхэлнэ.

-Зорчигчдын терминал хэсэгт лифт, цахилгаан шат байгуулах боломжтой юу?

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, тусгай тоног төхөөрөмж оруулж ирдэг компаниудтай хамтран аюулгүй, хүртээмжтэй цахилгаан эсвэл урсдаг шат хийх бүрэн судалгаа, шинжилгээ хийсэн. Ойрын хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна.

www.ubtz.mn

Төмөр замын нэгдсэн лавлах: 1900 1949

achaа.ubtz.mn

Ачаа тээврийн лавлах: 21-244137, 21-244138

eticket.ubtz.mn

Зорчигчийн галт тэрэгний лавлах: 21-24137, 21-24194



УБТЗ-ЫН 16 МЯНГАН АЖИЛЧДЫН ЦАЛИНГ ҮЕ ШАТТАЙГААР НЭМЛЭЭ

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт айлчлалын үеэр ОХУ-ын Оросын төмөр замууд Нээлттэй хувьцаат нийгэмлэгийн Ерөнхий захирал бөгөөд Ерөнхий хорооны дарга, Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлэгчийн эрхийг хэрэгжүүлэгч О.В.Белозёровой уулзаж, хоёр талын төмөр замын хамтын ажиллагааг өргөжүүлж, УБТЗ ХНН-ийн үйл ажиллагааг сайжруулах, хөгжүүлэх талаар дэлгэрэнгүй ярилцаж, үр дүнтэй шийдвэрүүдэд хүрлээ.

Уулзалтын үр дүнд

УБТЗ ХНН-ийн 16.000 орчим ажилтантай. Өндөр ур чадвар бүхий бэлтгэгдсэн, мэргэшсэн боловсон хүчнээ хадгалах, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын гэрээ, байгууллагын орлого, ашигтай уялдуулж, ажиллагсдын цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс цалингийн системийн

шинэчлэлийг эхлүүлж, нийт төмөр замчдын дундаж цалин хөлс 15 хувиар нэмэгдэхээр боллоо.

УИХ-аас баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050-ын зорилтуудтай уялдуулж, УБТЗ ХНН-г 2050 он хүртэл хөгжүүлэх стратегийг боловсруулна.

Орос-Монгол-Хятадын хооронд хил дамнуулан солилцох галт тэрэгний тоог өнөөдрийн түвшнээс бууруулахгүй байх, цаашид нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх,

Богдхан төмөр замын төслийн ТЭЗҮ-г яаралтай боловсруулж дуусган, хэрэгжүүлж, асуудлыг эрчимжүүлэх,

Зүүн босоо тэнхлэгийн барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан Эрээнцав-Чойбалсан хэсэглэлийн төмөр замын шинэчлэлийг эхлүүлэх,

Зүүнбаян-Сайншанд чиглэлийн төмөр замд их засвар хийж, экспорт, импорт, транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх,

Транзит тээврийн тарифын хөнгөлөлтийг

бууруулах асуудлыг судалж, УБТЗ ХНН-ийн хувь нийлүүлэгчдэд тодорхой шийдэл танилцуулах, Орос-Монгол-Хятад гурван улсыг дамнасан эдийн засгийн коридор байгуулах төслийн хүрээнд УБТЗ-ын тээх, нэвтрүүлэх хүчийн чадлыг нэмэгдүүлж, тээвэрлэх ачааны хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхээр хоёр тал тохирлоо. Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтын

ОХУ-д хийсэн айлчлал нь олон жил бугшсан, өр төлбөрийг цэгцэлж, төмөр замын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, цалинг нэмэгдүүлэх, төмөр замын их засвар, шинэчлэлт, шинээр баригдах төмөр замын төслийг эхлүүлэх, хөрөнгө оруулалт зэрэг олон асуудлыг шийдсэн, үр дүнтэй айлчлал болсныг онцлон тэмдэглэе.



ГАЛТ ТЭРЭГ СОЛИЛЦОО БА ТҮҮХЭН АМЖИЛТУУД

2023 оны хоёрдугаар сард хөрш орнуудын хилийн төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөнөөр Замын-Үүд - Эрээн боомтоор Хятадын талтай хоногт өргөн царигаар 15 галт тэрэг, нарийн царигаар 8 галт тэрэг, Наушки-Сүхбаатарын боомтоор Оросын талтай хоногт 10 галт тэрэг солилцож байхаар тохиролцсон нь 2015 оноос хойш гарсан том ахиц өөрчлөлт болсон. Энэхүү тохиролцоонд хүрэхээс өмнө Замын-Үүд - Эрээн өртөөгөөр Хятадын талтай хоног тутам өргөн царигаар 14 галт тэрэг, нарийн царигаар 6 галт тэрэг, Наушки-Сүхбаатарын боомтоор Оросын талтай 8 галт тэрэг тус тус солилцож байсан

юм. Дээрх шийдвэрийн үр дүнд өнөөдөр Замын-Үүд – Эрээн өртөөгөөр хоногт өргөн царигаар 15 галт тэрэг тогтмол солилцож байгаа бөгөөд ачааны урсгал нэмэгдсэн үед 16-17 галт тэрэг өргөн царигаар Эрээн өртөөнд хүлээлгэн өгч байна.

УБТЗ-ын хамт олон “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулагдсан түүхт ойн өдөр буюу 2023 оны 6 дугаар сарын 6-нд Замын-Үүд – Эрээн боомтын өргөн царигаар 18 галт тэрэг, нарийн царигаар 9 галт тэрэг солилцож түүхэн дээд амжилт тогтоолоо. Мөн Наушки-Сүхбаатарын боомтоор 10 галт тэрэг солилцсон нь түүхэн амжилтаар тооцогдож байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

“ УЛС ОРНЫ
ХӨГЖЛИЙН
ХУРДАСГУУР НЬ
ЗАМ ТЭЭВРИЙН
СЭРГЭЛТ



-Сайхан зусаж байна уу. Ажил алба ихтэй, зав чөлөө бага байна уу та?

-Сайхан зусаж байна. Урин дулаан энэ цагт манай салбарын хувьд ид ажил буцалдаг үе шүү дээ. Энэ жилийн төлөвлөгөөнийхөө голыг нугалах гэж манай салбарынхан цаг хугацаатай уралдан бүгд л зөв чөлөөгүй зүтгэцгээж байна. Манай зам тээврийн салбарт 42.500 гаруй үндсэн ажилтан албан хаагч бий гээд бодохоор том айл. Үүн дээр бүх төрлийн тээвэр эрхлэгчид, мэргэшсэн жолооч нар, зам барилгын чиглэлээр улирлын чанартай ажил эрхэлдэг хүмүүсээ нэмэх юм бол зуун мянга хол давна. Энэ бүх хүн бүгд л эдийн засгийн амьдралын хөдөлгүүр, хөтлөх хүч нь болсон салбарынхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж байгаа.

Ер нь улс орон хурдтай хөгжье, хүчирхэг эдийн засагтай больё гэвэл ерөөсөө зам тээврийн дэд бүтэц, тээвэр логистикийн хөгжилдөө л онцгой анхаардаг юм билээ. Тийм учраас би салбараа улс орны хөгжлийн судас гэж тодотгох дуртай. Манай салбарынхан бол энэ судсыг илүү олон, илүү өргөн болгож, эдийн засгийн хөгжилд зам тавьж байгаа хүмүүс. Өнөөдөр та бод доо. Замгүйгээр, тээвэргүйгээр нийгмийн амьдралыг төсөөлөх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр хүн бүрийн, айл болгоны, аж ахуйн нэгжээс өгсүүлээд улс орны бүхий л амьдрал манай салбартай салшгүй холбоотой.

-Та Зам, тээврийн хөгжлийн сайдаар томилогдсоноос хойш яг 10 сар болжээ. Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлаа товч тоймловол.

-Анх ажил авахад олон хүн их л амаргүй, асуудал ихтэй, хэл амтай, бас хийж бүтээж чадвал үр дүн нь олон нийтэд шууд анзаарагддаг онцлог салбарыг удирдах боллоо доо гэж хэлж байсан. Тэр нь ч үнэн байсан. Ер нь тэгээд ачаа үүрэхээр шийдсэн бол түүнийгээ даах л ёстой шүү дээ. Халгаж хулгаад, асуудлаас тойрч зугтаагаад байвал ажил явахгүй. Өнөөдөр бараг мартагдсан олон асуудал тэр үед манай салбарын төдийгүй нийгмийн толгойны өвчин байлаа шүү дээ. Тухайлбал

таван жил иргэдийг бухимдуулсан Дарханы замын ажил байна. Ерөнхий сайд нь хүртэл өөрөө очоод үүрэг өгч, хариуцлага тооцох хэмжээнд хүртлээ асуудал хүндэрчихсэн. Цемент байхгүй, битум байхгүй, машин техник байхгүй гэсэн бөөн шалтаг шалтгаан овоорчихсон. Энэ ажил руу яамныхантайгаа ханцуй шамлаад орсон. Би асуудал байгаа бол ард нь шийдэл заавал бий гэсэн зарчим барьдаг хүн. Тэр зарчим, тэр шаардлагаа тавиад зүтгэсэн. Зарим үед цементийн үйлдвэрийнхнийг дуудаж нүүр тулан уулзах, учирлах үе ч гарч байлаа. Долоо хоног бүрийн амралтын өдөр Дарханы зам руу давхина. Дэд сайдаа бүр тэнд байран суурин ажиллуулж хүртэл үзлээ. Тэгсний үр дүнд өнгөрсөн жил ямар ч байсан хөдөлгөөн нээсэн, өнөө жил энэ замыг бүрэн ашиглалтад оруулна. Дарханы замаас манайхан авах хамгийн том сургамж бол замаа тавьж эхлээгүй байж хуучныг нь бүгдийг хуулаад хаядаг дүнхүү алдааг л хэзээ ч, хаана ч давтаж болохгүй. Дээр нь зөв төлөвлөх, төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа шахах, асуудал гарсан бол томроогүй байгаа дээр нь дор дор нь шийдээд явах явдал.

Өөр нэг ноцтой асуудал байсан нь чингэлгийн гацаа. Тяньжинд, Эрээнд, Замын-Үүдэд, бүр Улаанбаатарт хүртэл чингэлэг гацчихсан. Иргэд, бизнесийнхэн хэдэн сараар хаа нэгтээ овоорсон чингэлгээ хүлээгээд цөхөрч бухимдсан асуудал байсан. Галт тэрэгний солилцоог яаралтай нэмэгдүүлж, төмөр замын тээвэр зохион байгуулалтаа оновчтой хийж энэ асуудлыг хурдан шийд гэдэг үүргийг УБТЗ-ын нөхдөд өгсөн. Сарын дотор энэ асуудал шийдэгдсэн. Чингэлгийн бөөгнөрөл, гацаанаас болж үнийн хөөрөгдөл үүсч, тээврийн зардал нэмэгдэж байсан тэр цаг хэдийнэ ард үлджээ.

Үр дүнд нь өнөөдөр тээврийн зардал 8-20 дахин буурч, импортын гацаанаас хамааралтай бараа бүтээгдэхүүний хомсдол ор мөргүй алга болсон байна. Нийгмийн жигшил дургүйцлийг хамгийн их хүргэсэн бас нэг асуудал болох нүүрсний хулгай, түүнтэй холбоотойгоор авлига авч вагон хурдлуулдаг булхай луйвар бас л бугшчихсан асуудал байсан. Ер нь юм олон нийтэд ил тод биш, далд байхлаараа л





авлига хүнд идээ буглаа үүсээд эхэлдэг. Сайд болохоосоо өмнө төмөр замын авлигын асуудлыг дэлгэж, шүгэл үлээж байсны хувьд ажлаа авсан цагаасаа энэ ёс бус явдлыг таслан зогсоох гэж тэмцсэн. Гол арга нь вагоны захиалгыг цахимжуулж, ил тод болгох байсан. Хэний хэзээ захиалсан вагон хаана яваа, хэзээ хаана очихыг, бүгд мэддэг байх боломжийг бүрдүүлэх гэж зүтгэсэн. УБТЗ ямар ч байсан энэ үйлчилгээгээ тодоохой хэмжээгээр цахимжуулаад явж байна. Одоо бүр улам ил тод, ойлгомжтой болох ёстой. Түүний тулд бид бүх вагоныг RFID-тай болгож олон нийт шууд хянадаг байх, иргэд, ААН-үүд ч өөрийнхөө чингэлэг, ачааг хаана явааг, хэзээ хаана ирэхийг мэдэх тэр боломжоор хангана. Энэ мэтээр асуудалтай нүүр тулж, шийдэл олж, ард нь гарч л явна.

-Тэр олон тулгамдсан асуудал, саад бэрхшээлтэй тулахад шантрах үе байв уу? Нийгмийн шүүмжлэлийн бай болсон газар очоод ажил хийнэ гэдэг тийм ч амар зүйл биш байх.

-Зовлон тоочоод, шалтаг тоолоод суувал ажил явахгүй. Асуудал байсан учраас л нийгэм олон нийт шүүмжилж байсан байж таарна. Тэр асуудлыг нь шийдэх чиг үүрэгтэй сайд байж шантраад, шалраад байх нь



МАНАЙ САЛБАРТ АСУУДЛААС ГАДНА АМЖИЛТ ДЭВШИЛ Ч ИХ БАЙСНЫГ ЭНД ХЭЛЭХ НЬ ЗҮЙТЭЙ

утгагүй л дээ. Тухайн үедээ мэдээж амаргүй л байсан. Харин шийдсэний, ард нь гарсны дараа бол ингээд зүтгэхэд болох юм байна шүү гэсэн урам зориг, дахиад дараачийн зорилго зорилтоо тодорхойлоод зүтгэх хүч сэлбэдэг юм билээ. Манай салбарт асуудлаас гадна амжилт дэвшил ч их байсныг энд хэлэх нь зүйтэй байх. 2022 онд бид 483 км авто зам, 500 метр гүүр шинээр ашиглалтад оруулсан. Азийн авто замын сүлжээний АН-4 баруун босоо тэнхлэгийн 745 км замыг бүрэн ашиглалтад оруулж Орос Хятад, Ази Европыг холбосон транзит тээврийг эхлүүлээ.

Манай улсын үндэсний төмөр замын сүлжээний урт 40 хувиар нэмэгдэж 2964,9 км боллоо. Монгол Улс шинээр 13 агаарын хөлөг хүлээн авч нийт 51 агаарын хөлөгтэй болсон. Дэлхийн 40 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж 23 улсын 100 цэгт нислэг үйлдэх боломж бүрдлээ гээд манай салбарынханы хувьд ард иргэддээ ам бардам хэлэх амжилтууд ч олон байлаа.

-Таныг Зам, тээврийн хөгжлийн сайд болоход цөөнгүй хүн, ялангуяа авто замчид манай салбарын хүн сайд боллоо гэж тун дуртай хүлээн авч байсан. Ямар учраас тэр вэ?

-Би ч өөрийгөө энэ салбартай амьдрал, хувь заяагаараа холбогдсон хүн гэж боддог. Төрийн ажил хийхээсээ өмнө хувийн хэвшилд, бүтээн байгуулалтын салбарт зүтгэж явлаа. Тэр үед би монголын авто замын ууган компаниудын нэг болох Зам гүүрийн контор буюу Алтайн зам компанийн хувьцааг Хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцож худалдаж авсан. Өмч хувьчлалын үед ихэнх нөхөд хувьцааг нь авсан байгууллагаа зориулалтаар

нь ажиллуулахгүй барилга байгууламжийг нурааж, тоног төхөөрөмжийг нь хураагаад худалдаад явчихдаг байсан.

Тухайлбал манай Ховдын хүнсний үйлдвэр, Бараа бааз, Тоосгон завод зэрэг олон объект тийм замаар орсон л доо. Харин би тэгээгүйдээ өнөөдөр бахархдаг. Олон ч газар авто зам тавьж, бүтээн байгуулалт хийж, аймаг сумдыг замтай болголцож монголын авто замын салбарын түүхийг бичилцсэндээ баярладаг. Тэр үед би бараг мэргэжлийн замчин болсон доо. Замынхаа трассыг тавина, дуран метр бариад өдөрт хэдэн арван км явган алхана, замын далан, асфальт хучилтын ажилд гар бие оролцоно, ер нь бараг практик дээр замын инженер болчихсон хүн. Тийм болохоор замчдын, тээвэрчдийн зовлон жаргалыг мэднэ. Тэр ажлын хүнд хэцүүг, бас сайн сайхныг ясандаа тултал мэдэрсэн хүн гэхэд хэтийдсэн болохгүй байх.

-Салбарынхаа дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтыг та хэрхэн харж байна. Энэ жил тавьсан зорилт тань хэр хэрэгжиж байна вэ?

-Хөгжил дэвшил бол өмнө очиж үзээгүй газартай адил. Тэнд хүрэх газрын зураггүй бол хол явахгүй. Тийм болохоор би байнга л хөгжлийн бодлого гэж ярьж ирсэнийг цөөнгүй хүн мэдэх байх. Тиймээс 2015 онд Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030-ыг санаачилж батлуулж байлаа. Хожим нь Монгол улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн санаачилсан Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "АЛСЫН ХАРАА-2050"-ыг УИХ-аар батлуулахад Ажлын хэсгийг нь ахалж байв.

2020 онд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийхэд Зөвшилцлийн ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж "Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлоготой байна" гэдэг заалт тусгуулж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай болоход хувь нэмэрээ оруулсан. Монгол Улсын Засгийн газрын ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО бол АЛСЫН ХАРАА-2050-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг, дунд хугацааны хөгжлийн бодлого. Энэ бодлого төлөвлөсөн хугацаандаа, заавал хэрэгждэг байх нь маш чухал гэж үзэж Ерөнхий сайд ч, Засгийн газар ч онцгой

анхаарал хандуулж байгаа. Ялангуяа ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-ын гол цөм нь манай зам тээврийн салбартай шууд холбогддог. Тийм учраас манай салбарын зорилт, төлөвлөгөө тодорхой. Түүнийг хэрэгжүүлэхийн тулд бид энэ оныг БҮРЭН ЦАХИМЖСАН, БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ХУРИУЦЛАГА ҮР ДҮНГ ТООЦОХ ЖИЛ болгон зарласан. Энэ хүрээнд түгжрэлгүй түргэн шуурхай төрийн үйлчилгээг бий болгоно гээд үндсэн зорилтоо тодорхойлоод ажиллаж байна.

Энэ жилийн төлөвлөлттэй холбоотой хэдхэн зүйл би хэлье. Юун түрүүнд Зам тээврийн салбарын хөгжлийн тулгуур болсон эрх зүйн орчноо шинэтгэх ажилд онцгой анхаарч байна. Тухайлбал, Төмөр замын тээврийн тухай, Иргэний нисэхийн тухай хуулиудыг шинэчиллээ. Удахгүй намрын чуулганаар Автотээврийн тухай хуулийг шинэчлэн батлуулах, авто замын норм норматив, стандартыг шинэчлэхийг чухалчилж байна. Энэ онд бид автотээврийн салбарт улс хоорондын 34,0 сая.тн ачаа, улс, хот хооронд 1.4 сая зорчигч тээвэрлэнэ гэсэн зорилт дэвшүүлсэн.

Оны эхний хагас жилийн байдлаар 28 сая тн ачаа тээвэрлэсэн нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 352%-иар өссөн байна. Өөрөөр хэлбэл бид авто тээврийн салбарт дэвшүүлсэн энэ жилийн төлөвлөгөөнийхөө 84%-ийг биелүүлчихээд байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 10 цэгт үйлчилгээний цогцолбор байгуулах ажил маань түрүүчээсээ гэрээ нь хийгдлээд ажил болоод явж байна. Ийм цогцолборууд олон болсноор жолооч зорчигчдын тав тух, авулгүй байдалд эерэг нөлөөтэй. Нөгөө талаар орон нутгийн хөгжлийг дэмжиж, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлж, хөдөөд шинэ үйлчилгээ бий болгож, үйлчилгээний соёлыг дээглүүлэхээс гадна байгаль орчин талдаа ч ээлтэй нөлөө үзүүлнэ. Сая бид улсын хэмжээнд автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, тооллогыг хийж мэдээллийн санг бүрэн шинэчлэх ажлыг хийлээ. Энэ ямар учиртай ажил вэ гэхээр манайхан малаа тоолж чаддаг шигээ машинаа бүрэн тоолох цаг болсон гэж үзсэнийх. Тэгэхгүй болохоор эвдэрсэн, ашиглахаа больсон, шатсан, эсхүл өөр хүнд зарсан машин тэрэг нь тухайн иргэний нэр дээр бүртгэлтэй



яваад л байдаг. Тэрэн дээр нь татвар торгуулийн өр үүсээд нэмэгдээд байдаг. Хэнэггүй, хайхрамжгүй байдлаасаа болоод хуримтлагсан өр төлбөрт ордог. Нэг талаар үүнээс нь схлгаж өгч байгаа юм. Нөгөө талдаа Монгол улс хэчнээн тооны, ямар маркийн машин тэрэг, тээврийн хэрэгсэлтэй юм, хэд хэчнээн нь хэдэн оных юм, ямар насжилттай юм гэдэг нарийн тооцоо судалгаатай болж байгаа юм. Энэ нь эргээд авто тээврийн бодлогоо зөв болгох, түгжрэлийг бууруулах, иргэдээ осол зөрчлөөс сэргийлэх гээд олон талын ач холбогдолтой. Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар

хоорондын хэлэлцээрийг 5 улстай байгуулах зорилт тавьсан. Сая л гэхэд Монгол улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Хятадын талтай хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Удахгүй АНУ, ХБНГУ, БНХАУ зэрэг улсын Тээврийн яамтай санамж бичиг байгуулна. ЧАНАРТАЙ ЗАМ-ЧАНСААТАЙ ЗАСВАР АРЧЛАЛТ зорилтын хүрээнд ирэх намар УБ-ДАРХАН чиглэлийн автозамыг байнгын ашиглалтад оруулна. Авто замын барилгын норм, нормативыг шинэчилж 2023 онд бид 540 км хатуу хучилттай авто зам, 500 у/м төмөр бетон гүүр барьж

ашиглалтад оруулна. Шинэ зам барихаас гагна одоо байгаа замаа хамгаалах, арчлах засварлах ажил түүнээс дутахгүй чухал. Энэ жил бид улсын чанартай авто замын их засварт зориулан 35.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусгасан. Энэ хөрөнгө оруулалтаар нийт 4 чиглэлийн 7 багц ажлын нийт 56.2 км авто замын их засварын ажлыг эхлүүлээд байна. Нийт 5 чиглэлийн 64 км авто замд гадаргуун боловсруулалт хийх, хучилтыг хүчитгэх, суурийг хүчитгэж хучилтыг шинэчлэх, нүхэн эвдрэлүүдийг засварлах ажлууд хийгдээд эхэлсэн. Дэлхийн банкны



зээлийн санхүүжилтээр улсын чанартай 361 км авто зам, 8 байршилд төмөрбетон гүүрийг засварлах ажил хийнэ. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар энэ онд 8 төслийн 225 км авто зам, 4 төслийн 1400 урт/метр төмөр бетон гүүрийн зураг төсөл боловсруулахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. Өөрөөр хэлбэл энэ жил хийх ажлаасаа гадна ирэх жилүүдэд хийх ажлынхаа зургийг гаргаж байна гэх үү дээ. Саяхан бид ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-ЗАМ ТЭЭВРИЙН СЭРГЭЛТ хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулсан. Энэ үеэр Арц суурь-Нарийн сухайт-Шивээхүрэн төмөр замын хувьцаа эзэмшигчдийн гэрээ,

3000 ширхэг вагон худалдан авах гэрээ, Улаанбаатар-Хархорин чиглэлийн хурдны төмөр замын ТЭЗҮ боловсруулах санамж бичигт холбогдох байгууллагууд тус тус гарын үсэг зурсан тодорхой үр дүнтэй ажил боллоо. Мөн энэхүү чуулган болон Ерөнхий сайдын Хятадад хийсэн айлчлалын үеэр болсон МОНГОЛ ХЯТАДЫН БИЗНЕСИЙН ФОРУМ-д хөрөнгө оруулалт шаардлагатай томоохон төслүүдээ хөрөнгө оруулагч нарт танилцууллаа. Тухайлбал хилийн 11 боомтоо авто замаар, 4 боомтоо төмөр замаар холбох, баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр зам барих, Алтанбулагаас-Дархан-Налайхаас-Замын-Үүд хүртэлх АН-3 авто

замын коридорыг өргөтгөн шинэчлэх, орон нутгийн 4 нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгож агаарын ачаа тээврийн терминал байгуулах, Улаанбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Ховд, Чойбалсанд хуурай боомт байгуулах, Улаанбаатар-Хархорин чиглэлд хурдны галт тэрэг аялах шинэ төмөр замын төсөл хэрэгжүүлэх зэрэг томоохон төслүүдээ хөрөнгө оруулагч нарт танилцууллаа. Мөн Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулахад томоохон нөлөө үзүүлэх "Туулын авто зам төсөл"-ийн зураг төслийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Энэ төслийн зам барилгын ажлыг төр, хувийн хэвшлийн

түншлэлийн хүрээнд “барих-ашиглах-шилжүүлэх” боломжит төрлөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж сонирхсон хөрөнгө оруулагч нартай нээлттэй уулзан төслөө танилцуулж байна. Энэ ондоо багтаад Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам, Алтай-Улиастай чиглэлийн 178 км хатуу хучилттай авто замыг ажлыг эхлүүлчихнэ гэсэн бодолтой байна.

-Бид хүний зан, машин зам хоёр сайхан байхад амархан дасдаг. Харин муудах юм бол дороо анзаардаг, эмзэглэдэг, асдаг дүрэлздэг араншинтай ард түмэн биш үү.

-Өнөөдөр бид 21 аймаг 96 сумаа хатуу хучилттай авто замтай болгоод байна. Ховд аймаг 16 сумын дийлэнх нь хатуу хучилттай авто замтай болж, урд хойд хөрш, Улаанбаатар хоттой холбогдсон босоо хэвтээ тэнхлэгийн 1200 гаруй км хатуу хучилттай замтай болсон. Зам дагаж хөгжил гэдэг. Манай замчид тосон замын буян ч гэдэг. Үнэхээр холыг ойртуулж, хөгжлийг дөтөлсөн олон сайхан замууд баригдлаа. Хүн бүр зам ашиглагч. Тэгэхээр зам ашиглаж буй хэн бүхэн замаа хайрлах, хамгаалах, даач хэтрүүлэхгүй байх тал дээр нь анхаарах ёстой. Нөгөө талаас салбарын яам аль болох богино хугацаанд, бага ертгөөр чанартай зам барих талд бодлогоо чиглүүлнэ. Зам арчлалт гэдэг хүн өглөө орой

бүр шүдээ угаадагтай адил байнга тогтмол хийж байх ёстой зүйл. Тэгж арчлахгүй бол яг л хүний шүд шиг зам цоорно, өвчилнө, эмтэрнэ. Тэгэхээр замаа хайрлах нь, анх баригдахаас нь эхлээд чанартай, чансаатай зам барихад анхаарах нь тун чухал. Замыг барихдаа ч, арчлахдаа ч, ашиглахдаа ч хүнийрхүү сэтгэлээр хандаж огт болохгүй л дээ.

-Иргэний нисэхийн салбарт сэргэлт хамгийн тод ажиглагдаж байна. Анх таныг олон улсын нислэгийн тоог нэмж, орон нутгийн 9 чиглэлийн нислэгийг сэргээнэ гэхэд сайхан тууж өгч байна даа л гэж харж байсан хүний нэг нь би. Гэтэл өөрөө сая Говь-Алтай руу нисээд ажлаа хурдан шуурхай амжуулаад ирлээ. Үнэхээр амар болжээ.

- Яг үнэн. Анх намайг орон нутгийн нислэгийг сэргээнэ, тийзний үнийг бууруулна гэхээр итгэх хүн ховорхон л байсан. Монгол Улсын Засгийн газрын ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО-д агаарын тээврийн либералчлалыг эрчимжүүлнэ гэсэн нэг өгүүлбэр байгаа. Энэ хүрээнд манай төрийн өмчит МИАТ компани нийгмийн хариуцлагын хүрээнд агаарын тээврийн салбартаа “айлын том ах шиг байж” алдагдалгүй, бас ашиг харахгүй, төсвөөс татаас нэхэхгүйгээр орон нутгийн 9 чиглэлд 7 хоногт 1-3 удаа хямд бөгөөд хүртээмжтэй нислэг үйлдэж эхэллээ. Олон хүн баярлаж байна. Орон нутгийн нислэгүүд сэргэсэнээр

жинхэнэ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ болж баниа гэж над руу ярьж бичиж байна. Хөгшин хөвөө, нялх нойтон хүүхэдтэй болон газраар зорчих боломжгүй өвчтэй зовлонтой иргэд агаарын тээврээр зорчих боломж нээгдсэнд ёстой магнай хагартал баярлаж байгааг мэдрэх сайхан байна. Энэ Засгийн газар 2023-2025 оныг МОНГОЛД ЗОЧЛОХ ЖИЛ болгон зарласан. Зочлоорой гэж уриад авчрах, тээвэрлэх, үйлчлэх унаагүй бол хоосон уриа л болоод өнгөрнө. Тийм болохоор тэдэнд үйлчлэх тэнгэрийн хүлгээ бид бэлдэх ёстой болсон. Гаднаас авчирчихаад нөгөө жуулчдаа Улаанбаатарт уяад, уйдаагаад байж таарахгүй. Тэд чинь ихэнх нь орон нутагт аялах, байгалийн үзэсгэлэнт газруудад очих л гэж ирж байгаа. Тэр боломжийг нь нээж аялал жуулчлалыг хөгжүүлэхэд энэ тун нэмэр болж байгааг та нүдээр үзэж биеэр мэдэрсэн нь сайн хэрэг. Хамгийн нол нь орон нутгийн нислэгийн тийз 2-оос 2.5 дахин хямдарснаар иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлж, зардлыг хэмнэх бодит бололцоог бүрдүүлж юм байгаа юм. Сая та Алтай руу хоёр талдаа 852 мянган төгрөгөөр явж ирсэн байх. 2 мянган км газар оччихоод ирэхэд нэг жуулчин 240 ам доллар нислэгтээ зарцуулна гэдэг боломжийн гэж манай аяллын компаниудын нөхөд хэлж байна билээ. Миний сайд болсон цагаасаа яриад байгаа ХЯМД ТИЙЗ-ХҮРТЭЭМЖТЭЙ нислэг гэдэг зорилт эхнээсээ ажил болж байгаад баяртай байлгүй яахав. Удахгүй АНУ-тай OPEN

SKY хэлэлцээр байгуулах гэж байна.

-Монголчууд төмөр замаа өөрсдөө барьж байгуулж чаддаг болсон. Гэхдээ энэ хүртэл алдаа оноо ч чамгүй гаргах шиг боллоо. Одоо төмөр замын салбарын хэтийн хөгжлийг том зургаар нь харвал ямархуу зүйл танд төсөөлөгдөж байна?

- Нэгдүгээрт, монголчууд төмөр зам барьж чаддаг гэдгээ харуулсан нь бахархам амжилт юм шүү. Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км замыг л гэхэд наймхан сарын дотор барьсан. Ингэхээр бид дараа дараачийн жилүүдэд үүнээс ч илүү төмөр замыг барих хангалттай нөөц, бололцоо бий гэж харж байна. Гол нь бодлого, менежментийн хувьд зөв явбал шүү дээ. Хил холболтын цэгээ тохироогүй мухар барьсан нь анхнаасаа бодлогын алдаатай шийдвэр байсныг үгүйсгэхгүй. Өнгөрсөн тавдугаар сард Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын ТЭЗҮ боловсруулах, зураг төслийн гэрээгээ байгуулчихсан. Удахгүй л төмөр замаа бариад, урд айлтайгаа холбочихно. Шивээхүрэн-Сэхээ чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт эхэлчихсэн. Хоёрдугаарт, цаашид бид төмөр замаа барихдаа эхлээд хил холболтын төмөр замаа барих ёстой. Эдгээрээс гадна Сайншанд-Баруун-Урт-Хөт чиглэлийн 394 км төмөр зам, хостөмөрзамтай болох, Улаанбаатар-Хархорин чиглэлийнд 384 км хурдны төмөр зам барих гээд бүтээн байгуулалтын олон ажил хийхээр байна. Төр нэгдсэн, зөв бодлого баримталж, хувийн хэвшилтэйгээ хамтран менежментээ зөв хийснээр алдаагаа давтахгүй.

- Монголд чинь ингэхэд хэдэн мянган тээвэрчин байдаг юм бэ. Тээврийн салбарын хөгжлийн тухайд юу хэлэх вэ?

-Тээвэрчид бол өрхийнхөө, манай улсын эдийн засгийг нуруундаа үүрч буй хүмүүс. Манай улсад 80.000 гаруй тээвэрчин бий. Ковидын үед хамгийн их хохирсон хүмүүс бол тээвэрчид шүү дээ. Зам, тээврийн хөгжлийн яам нь тээвэрчдээ бодлогоор дэмжих, хамтарч ажиллах ёстой болохоос нуруугаа харуулаад байж болохгүй. Зовлон, жаргалыг нь ойлгодог байх хэрэгтэй. 2023 оны эхний хагас жилд

28.49 сая.тонн ачаа тээвэрлэсэн нь 2022 онтой харьцуулахад 352 хувиар өссөн дүнтэй байна. Тээврийн салбар үлэмж хөгжиж байна. Тухайлбал, хилийн боомтуудын ачаа тээвэрт AGV буюу автомат удирдлагатай тээврийн хэрэгслийг нэвтрүүлж, хүний хөдөлмөрийг хөнгөвчилдөг боллоо.

Ерөнхий сайдын БНХАУ-д айлчлах үеэр хоёр улсын автотээврийн хэлэлцээрт гарын үсэг зурж албажууллаа. Ингэснээр байнгын ачаа тээвэрлэлтэд улирал бүр олгодог хэл ам дагуулсан С зөвшөөрлийн хугацааг 120 хоног болгож уртасгалаа.

Худалдаа, тээврийг хөнгөвчлөх үүднээс тээвэрлэлтийн баримт бичгийг цахимжуулж, Монголын тээвэрчид гуравдагч хөрш рүү, Киргизстан, Тажикстан зэрэг дундад азийн орнууд руу мах экспортлох, жимс жимсгэнэ импортлох шинэ гарцтай болгож байна.

-Хөрөнгө оруулалт, шинэ мэдлэг, шинэ техник технологи, дэлхийтэй хөл нийлүүлэн хөгжих боломж бий юү?

-Зам, тээврийн салбарт хөрөнгө оруулалт хамгийн чухал. Манай салбарт 10 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн тооцоолол бий. Саяхан бид анх удаа “Шинэ сэргэлтийн бодлого Зам, тээврийн сэргэлт” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулсан. Хөрөнгө оруулагчдадаа ээлтэй, итгэлийг нь алдахгүй, хэлсэндээ хүрдэг, харилцанашигтай хамтынажиллагааг эрхэмлэх нь зүйтэй. Чуулга уулзалтын үеэр Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын хувьцаа эзэмшигчдийн гэрээ, 3000 ширхэг вагон худалдан авах, Улаанбаатар-Хархорин чиглэлийн хурдны замын ТЭЗҮ боловсруулах гэрээг байгуулсан үр дүнтэй чуулган болсныг онцлон хэлмээр байна.

Цаашид хилийн 11 боомтоо авто замаар, 4 боомтоо төмөр замаар холбож, баруун, зүүн босоо тэнхлэгийн төмөр зам, Алтанбулаг-Налайх-Замын-Үүд хүртэлх АН-3 авто замын коридорыг өргөтгөх, орон нутгийн 4 нисэх буудлыг олон улсын болгож ачаа тээврийн терминал байгуулах, Улаанбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Ховд, Чойбалсанд хуурай боомт байгуулах зэрэг томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалт хэрэгтэй байна. Ингэж байж дэлхийн хөгжилтэй хөл нийлнэ шүү дээ.


АВТО ТЭЭВРИЙН СЭРГЭЛТ



“АЗИ-ЕВРОПЫГ ХОЛБОСОН АВТОТЭЭВЭР”

Өнгөрсөн онд манай улс баруун босоо тэнхлэгийн АН-4 авто замыг бүрэн ашиглалтад оруулсан. Өөрөөр хэлбэл, Орос, Хятад цаашлаад Ази Европыг холбосон эдийн засгийн хоёр дахь коридортой болсон. Харин одоо Ази Европыг холбосон энэ коридороор ОХУ-БНХАУ-ын транзит тээврийг эхлүүлэхийг нэн тэргүүнд чухалчилж байна. Энэ хүрээнд 2023 онд авто тээврээр 34 сая тонн ачаа тээвэрлэх зорилт дэвшүүлээд байна.

Мөн тээврийн үйлчилгээг илүү хөнгөвчилж, хүртээмжтэй болгохын тулд авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг бүрэн цахимжуулах ажлыг хийлээ. Олон улсын болон дотоодын авто зам дагуу 10 цэгт үйлчилгээний цогцолбор байгуулах ажлыг эхлүүлсэн. Түүнээс гадна олон улсын тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг



МОНГОЛ ХЯТАД БОЛОН ГУРАВДАГЧ УЛСТАЙ ХИЙХ ГАДААД ХУДАЛДАА ӨРГӨЖИХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны зургаадугаар сарын 26-29-ны өдрүүдэд БНХАУ-д албан ёсны айлчлал хийлээ. Энэ айлчлалын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын олон улсын автотээврийн харилцааны тухай хэлэлцээрийг шинэчиллээ.

Хэлэлцээрийн үр дүнд:

Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтэд улирал бүр олгодог С зөвшөөрлийн хугацааг 120 хоног болгож уртасгав.

Хоёр улсын худалдаа, тээврийг хөнгөвчлөх үүднээс тээвэрлэлтийн баримт бичгийг цахимжуулах нөхцөлийг бүрдүүлэхээр тохиролцов.

Монголын тээвэрчид гуравдагч хөрш рүү, тодруулбал Киргизстан, Таджикстан зэрэг дундад азийн орон руу авто тээврээр мах экспортлох, жимс жимсгэнэ импортлох шинэ гарцыг бий болголоо.

Ачаа тээвэрт AGV шинэ тээврийн төрөл, шинэ технологийг нэвтрүүлэхэд саадгүй болгов.

Хоёр улсын хооронд ТИР конвенцийн хүрээнд ачаа тээвэрлэлт нэмэгдэх нөхцөл бүрдлээ.

Монгол Хятад болон гуравдагч улстай хийх гадаад худалдаа өргөжих боломж бүрдэв.

МАНАЙ УЛС 20 ГАРУЙ УЛСТАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ДАГУУ АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААТАЙ



Зам тээврийн хөгжлийн яам нь авто тээврийн салбарт жолооч, тээвэрчдийг дэмжих бодлого барьж байгаа. Цар тахлын үед тээвэр үнэ өндөр байсан. Энэ үед тээвэртэй холбоотой аливаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хүн бүрт тээврийн бололцоо олгох өрсөлдөөнийг дэмжсэний үр дүнд тээврийн зардал 20 дахин буурсан. Мөн олон улсын авто замын сүлжээний АН-4 коридороор ОХУ-БНХАУ-ыг холбосон транзит тээврийг эхлүүлээд байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД :



МАНАЙ УЛСЫН
ТЭЭВЭРЧИД ОЛОН
УЛСАД ТРАНЗИТ
ТЭЭВЭР ХИЙХ
ГАРЦ НЭЭГДСЭН



“АН-4 буюу баруун босоо тэнхлэгийн энэхүү зам нь Монгол Улсын төдийгүй бүс нутгийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулна. Энэхүү бүтээн байгуулалт 2012 оноос хойш үе шаттайгаар явж, ийнхүү дуусаж байна. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, CAREC-ийн 4”а” коридор, үндэсний томоохон бүтээн байгуулалтын нэг, Ази Европыг холбосон 745 км босоо тэнхлэгийн энэхүү авто замыг Монгол Улсын төсөв, БНХАУ-ын Засгийн газрын зээл, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барьсан.

Энэхүү тээврийн коридор нь БНХАУ, Шинжаан Уйгурын Өрөмч, Ховд аймгийн Булган боомт,

Ховд, Баян-Өлгий аймгийн төв, Цагаануур боомтоор дамжин ОХУ-ын Новосибирск хүртэлх 4500 км гаруй юм. Монгол Улс газарзүйн байрлалын давуу талаа ашиглан Ази, Европыг холбосон транзит коридороо байгууллаа. Ингэснээр тус бүсэд томоохон үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж, бүтээгдэхүүнээ экспортлож эдийн засагт өндөр хувь нэмэр оруулна.

Мөн манай улс 20 гаруй улстай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу автотээврийн харилцаатай. Олон улсын болон бүс нутгийн тээвэрлэлтэд манай тээвэрчид оролцдог. Энэ коридороор ч бусад орны болон манай улсын тээвэрчид олон улсад транзит тээвэр хийх боломж бүрдлээ” гэв.

ӨРСӨЛДӨӨНИЙГ ДЭМЖСЭНИЙ ҮР ДҮНД 2023 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД ТЭЭВРИЙН ЗАРДАЛ 20 ДАХИН БУУРСАН

Цар тахлын үед Эрээн Улаанбаатарын хооронд 1м/куб ачааны тээврийн хөлс 3000 юань хүрч тэнгэрт хадаж байсан. Дунджаар 1 чингэлэгт 64м/куб ачаа ордог гэж үзвэл тээврийн хөлс нь 192000 юань буюу 86 сая 400.000 төгрөгт хүрч байв. Хил нээгдсэнээр Эрээнээс Улаанбаатар хүртэлх чингэлэг тээврийн хөлс өнөөдрийн ханшаар 3 сая 900.000 төгрөг болж 20 дахин буураад байна.



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Б.ГҮРСОРОНЗОН

ЗАМЫН-ҮҮД БООМТООР өдөрт 200-250 ачааны автомашин, том оврын 7-12 автобус 120-294 зорчигч БНХАУ-руу нэвтрэн тээвэрлэлт хийж байгаа. Харин экспортын 20-23 машин гарч байна. Тарифын хувьд Эрээнээс Замын-Үүд 24 тн буюу 63 м3 ачаа 4500 юань буюу 2,000,000-2,200,000 төг, Эрээнээс Улаанбаатар чиглэлд 5,000,000-5,300,000 төгрөгийн ханштай байна. Цар тахлын үетэй харьцуулбал ачаа, тээврийн үнэ буурах төлөвтэй байгаа.

ХАНГИ БООМТООР өдөрт 180-220 тээврийн хэрэгсэл хилээр нэвтрэх 15,000-20,000 тн нүүрс, уул уурхайн

бүтээгдэхүүний тээвэрлэлт хийж байна. Үнэ тарифын хувьд Гаалийн хяналтын талбайгаас 1 тонн нүүрс 20.160 төг ханштай.

Бичигт боомтоор өдөрт 200-240 тээврийн хэрэгсэл нэвтрэн хилийн шугам дээр ачаа солилцох байдлаар 15,000-16,000 тн нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийж байна.

ГАШУУНСУХАЙТ БООМТООР өдөрт нүүрс тээврийн 900-1000 тээврийн хэрэгслээр 130,000-150,000 тн нүүрс, 70-80 орчим тээврийн хэрэгслээр 2,800-3,200 тн зэсийн баяжмал, импортын ачааны 8-12 автомашин хилээр нэвтрэн тээвэрлэлт хийж байна. Тарифын хувьд уртын тээвэрт тонн тутамд 28,800-38,400 төг, богинын тээвэрт 38,400-48,000 төгрөгийн ханштай.

ШИВЭЭХҮРЭН БООМТООР өдөрт нүүрс тээврийн 350-400 орчим автомашин хилээр нэвтрэн 50,000-57,000 тн нүүрсний экспортын тээвэрлэлт хийж байна. Тарифын хувьд 1 тонн тутамд 33,600 төгрөгийн ханштай. Одоогоор хилийн шугам дээр чингэлэг солилцож байгаа. Удахгүй хятадын тал руу жолооч нарыг нэвтрүүлнэ гэсэн албан мэдээтэй байна.

БАЯНХОШУУ БООМТООР өдөрт 45-50 орчим тээврийн хэрэгсэл хилээр нэвтрэх 12,000-14,000 баррель газрын тосыг хилийн шугам дээр чиргүүл солилцох байдлаар тээвэрлэлт хийж, Булган боомтоор мөн ачаа зорчигч тээвэрлэлт хэвийн горимд шилжсэн. Өдөрт 100-120 орчим тээврийн хэрэгсэл 8,000-10,000 тн нүүрсний тээвэрлэлт хийж байна.

БУРГАСТАЙ БООМТООР өдөрт 10-20 орчим тээврийн хэрэгсэл 390-410 тн төмрийн хүдрийн тээвэрлэлт хийж байгаа. -ОХУ-тай хиллэдэг боомтуудын тээврийн нөхцөл байдлын талаар? -Алтанбулаг боомтоор өдөрт импортын 700-900 тн ачаатай 30-54 тээврийн хэрэгсэл,

ЦАГААННУУР БООМТООР 40-50 тээврийн хэрэгсэл, Боршоо боомтоор 150-250,5 тн ачаа бүхий 8-11 орчим ачааны автомашин тус тус орж ирж байна.



ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД РУУ ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

Бүгд Найрамдах Серби Улс болон Бүгд Найрамдах Азербайжан Улстай харилцан тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлж, Себрийн талтай хоёр талын болон дамжин өнгөрөх ачаа тээврийн, гуравдагч улсын тээвэр, Азербайжаны талтай хоёр талын болон гуравдагч улсын тээвэр хийх зөвшөөрлийг солилцсоны үр дүнд ОХУ – Гүрж – Серби – Турк улсаар дамжин Европын холбооны улсууд руу тээвэрлэлт хийх боломж бүрдээд байна.



БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛСТАЙ АВТО ТЭЭВРИЙН ХЭЛЭЛЦЭЭР ҮЗЭГЛЭНЭ

“Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр “Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээрийг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэн дэмжигдэж, гарын үсэг зурахад бэлэн болоод байна.




ПОЛЬШ УЛСТАЙ АВТОТЭЭВРИЙН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛЛАА

Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Польш Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт хоёр тал 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурж, хэлэлцээр байгууллаа.



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТЭЭВЭРЛЭЛТ НЭМЭГДЛЭЭ

Бүгд Найрамдах Серби Улс болон Бүгд Найрамдах Азербайжан Улстай харилцан тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлж, Себрийн талтай хоёр талын болон дамжин өнгөрөх ачаа тээврийн, гуравдагч улсын тээвэр, Азербайжаны талтай хоёр талын болон гуравдагч улсын тээвэр хийх зөвшөөрлийг солилцсоны үр дүнд ОХУ – Гүрж – Серби – Турк улсаар дамжин Европын холбооны улсууд руу тээвэрлэлт хийх боломж бүрдээд байна.



БНХАУ-ТАЙ АВТОТЭЭВРИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ШИНЭЧИЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр “Олон улсын автотээврийн харилцааны тухай” Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, Засгийн газрын 2023 оны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, “Гарын үсэг зурах эрх олгох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 115 дугаар захирамж батлагдан гарлаа. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд БНХАУ-д айлчлах албан ёсны айлчлалын үеэр хоёр тал уг хэлэлцээрт гарын зурлаа.




ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН СОЁЛЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан улс, хот хооронд, орон нутгийн нийтийн тээвэр болон жуулчин тээврийн үйлчилгээнд чухал ач холбогдолтой олон ажил хийлээ.

Тухайлбал, 2023 оны эхний 6 сард 24 мянган гадаадын жуулчинд үйлчилгээ үзүүлээ. Жолооч нарын дүрэмт хувцас болон тээврийн хэрэгсэлд монголд зочлох жилийн логог байршуулж, “Жуулчин тээврийн үйлчилгээний соёл, аюулгүй байдалд жолоочийн гүйцэтгэх үүрэг”, “Харилцаа хандлага сайжруулах” сургалтад 1000 жолоочийг хамрууллаа.



Та онлайн болон цаасан тасалбар дээрх
9 оронтой кодоо ашиглан **77 номыг**
2,000 төгрөгөөр уншиж сонсоорой.



www.mplus.mn

80026363

Mplus – ийн Үйлчилгээний төрлүүд



Бизнес эрхлэгчдэд туслах



Данс нь хэзээ...
Б. Цэндраг



Баян эмэгтэй
Ковч Кийнхавсала



Бизнес өрөг...
Б. Болорчигел



Стори Брэнд...
Доналд Мейлор



Factfulness
Ханс Рослинг



Жижиг...
Майкл Ж. Фелд

НОМТОЙ АВТОБУС АЖИЛЛУУЛЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан улс, хот хооронд, орон нутгийн нийтийн тээвэр болон жуулчин тээврийн үйлчилгээнд чухал ач холбогдолтой олон ажил хийлээ.

Тухайлбал, 2023 оны эхний 6 сард 24 мянган гадаадын жуулчинд үйлчилгээ үзүүлээ. Жолооч нарын дүрэмт хувцас болон тээврийн хэрэгсэлд монголд зочлох жилийн логог байршуулж, “Жуулчин тээврийн үйлчилгээний соёл, аюулгүй байдалд жолоочийн гүйцэтгэх үүрэг”, “Харилцаа хандлага сайжруулах” сургалтад 1000 жолоочийг хамрууллаа.



ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭВ

Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 иргэдэд хүртээмжтэй, мэдээллээ шуурхай байлгахар Сонгинохайрхан, Баянзүрх автотээврийн төв, цирк салбар, 21 аймгийн автотээврийн төвүүдэд нэмэлтээр лавлах үйлчилгээний шугам нээж ажиллуулж байна. 2023 оны зургадугаар сарын 20-ны өдрийн байдлаар 456.847 дуудлага мэдээлэлд хариулт өгч, иргэдэд тулгарсан асуудлыг шуурхай шийдвэрлэсэн байна.



АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР 1.181.280 ТОНН НҮҮРС ТЭЭВЭРЛЭЖЭЭ

Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор 2022 оноос эхлэн АГУ буюу автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр тээвэр хийж, нийт 1.181.280 нүүрс тээвэрлэлээ. Ингэснээр хүний хөдөлмөрийг хөнгөвчилж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж байна.



АВТО ЗАМЫН СЭРГЭЛТ


ЧАНАРТАЙ ЗАМ-ЧАНСААТАЙ ЗАСВАР АРЧЛАЛТ



Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт өнөөгийн байдлаар 112 мянган км бөгөөд 21 аймаг, 96 сум, 5 хилийн боомт нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдож, эдийн засгийн хөгжлийн судсаа тэлэн, тээврийн зардлыг бууруулж, иргэд аюулгүй, ая тухтай зорчих боломж бүрдээд байна.

Зам, тээврийн хөгжлийн яам 2023 онд улсын хэмжээнд 546 км хатуу хучилттай авто зам, 229 у/метр гүүр ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Мөн эдийн засгийн гол коридор Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын өргөтгөл шинэтгэлийн ажлыг 2023 онд бүрэн дуусгахаар замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүллээ. Хоёр урсгал дөрвөн эгнээ бүхий уг зам нь ачаа тээврийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэгтэй юм.

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН ХОЁР УРСГАЛ ДӨРВӨН ЭГНЭЭ БҮХИЙ ЗАМ ЭНЭ ОНД АШИГЛАЛТАД БҮРЭН ОРНО



Зам, тээврийн хөгжлийн яам энэ онд авто замын салбарт “Чанартай зам-чансаатай арчлалт, засвар” зорилтыг дэвшүүлэн замыг чанарта барьж гүйцэтгэх, цаг тухайд нь засвар арчлалтыг хийхэд анхаарч байна. Авто замын салбарт 2023 онд хэд хэдэн бүтээн байгуулалт, зам засвар үйлчилгээг хийхээр төлөвлөсөн юм. Тухайлбал, Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам, Алтай-Улиастай чиглэлийн 178 км хатуу хучилттай авто замыг эхлүүлж, Дорнодын Хавиргын боомт, Урьханы боомт руу зам барих төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түүнчлэн Улаанбаатар-Дархан чиглэлийн хоёр урсгал, дөрвөн эгнээ зам энэ онд

бүрэн ашиглалтад орно. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлт болон нэмэлт хоёр эгнээ автозам барих төслийг Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийж буй одоо байгаа авто замыг өргөтгөн шинэчлэх төслийг таван багц хэсэгт хуваан хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар нийт гурван багцын барилгын ажил дуусаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээгээд байна. Үлдсэн хоёр багцын ажил болох хоёрдугаар багцын ажил 72 хувь, дөрөвдүгээр багцын ажил 58 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ:

“**МОНГОЛЫН АВТО
ЗАМЫН САЛБАР
МАШ ХУРДАЦТАЙ,
ҮСРЭНГҮЙ
ХӨГЖИЖ БАЙНА**”



Манай улс өргөн удам газар нутагтай ч хүн ам цөөтэй учраас хол зайд урт замууд баригддаг. Эрс тэс уур амьсгалтай тул барилгын ажлын хугацаа богино байх онцлогтой. Гэсэн хэдий ч анх мянганы замын тухай төлөвлөж, барьж эхлүүлж байхад хол сонсогддог байсан. Бид үндсэндээ голлох зорилтуудаа биелүүлж 21 аймгаа хатуу хучилттай авто замаар бүрэн дүүрэн холбох ажлыг 2022

онд амжилттай дуусгасан. Бусад улс оронтой харьцуулахад хүн ам, газар нутгийн хэмжээ, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зэргийг харьцуулахад бүх аймгаа, “Нутгийн зам” хөтөлбөрийн хүрээнд 100 орчим сумыг хатуу хучилттай авто замаар холбосон нь маш том үзүүлэлт. Монголын авто замын салбар маш хурдацтай, үсрэнгүй хөгжиж байна гэж дүгнэж болохоор байна.

“Монгол Улсын авто замын сүлжээ 112 мянга гаруй км, үүнээс олон улс, улсын чанартай 14921.3 км авто замтай бөгөөд 7485.6 км хатуу хучилттай авто зам. 17482.1 у/метр гүүр, тусгай зориулалтын буюу хүнд даацын 908.6 км авто замыг барьж ашиглаж байна.”



Авто замын засвар арчлалтын ажлыг урсгал, ээлжит, их засвар гэж хуваадаг. Урсгал засварыг жил бүр төлөвлөгөөний дагуу, ээлжит засварыг 3-5 жил тутамд хийдэг. Цаг агаарын эрс тэс уур амьсгалаас шалтгаалж, манай улсын авто зам өвөл хөлдөж, зун халж, хавар, намарт гэсдэг онцлогтой. Температурын болон бусад нөлөөллөөс замын өнгөн хэсэгт хагарал үүсэж, доод бүтээцүүдэд ус нэвчсэнээр эвдрэл үүсдэг. Хавар, намрын хөрсний гэсэлтийн үед хучилтын бүтээц эмзэг болсон замаар том оврын тээврийн хэрэгслийн нөлөөгөөр ямар ч сайн чанартай авто зам эвдрэх нөхцөл бүрддэг. Ийм ан цавын хагарлыг гагнах ажлыг халуун, хүйтэнд хийж болдоггүй, жил бүрийн энэ хугацаанд гүйцэтгэдэг. Энэ мэт урсгал засварын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна.

ЭХ ОРНЫ ХӨГЖЛИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД АВТО ЗАМЧДЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО ЧУХАЛ



ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТАД 500 ГАРУЙ АВТО ЗАМЧИД ОРОЛЦОЖ, САНАЛ, ШИЙДЛЭЭ НЭГТГЭЛЭЭ

Монгол Улсын эдийн засгийн “хөгжлийн судас” болсон авто замын салбарынхан “ЧАНАРТАЙ ЗАМ-ЧАНСААТАЙ ЗАСВАР АРЧЛАЛТ” зөвлөлдөх уулзалт /2023.04.27/ өдөр Төрийн ордны Их танхимд боллоо. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” илтгэлээр зөвлөгөөнийг эхлүүлж, эх орны хөгжлийн бүтээн байгуулалтад авто



замчдын үүрэг, оролцоо чухал гэдгийг онцлов. 2013 оноос хойш 10 жилийн дараа болж буй авто замчдын зөвлөгөөнийг УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт “Төрөөс авто замын салбарыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлэх арга зам”, “Авто замын салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” зэрэг илтгэл танилцуулагдаж, хэлэлцүүлээ.



УЛСЫН ЧАНАРТАЙ АВТОЗАМЫН ИХ ЗАСВАРТ ЗОРИУЛАН 35,5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ 2023 ОНЫ УЛСЫН ТӨСӨВТ ТУСГАН ШИЙДВЭРЛҮҮЛЭВ

Улсын чанартай авто замын их засварт зориулан томоохон хэмжээний буюу 35.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2023 оны Улсын төсөвт тусган шийдвэрлүүлсэн бөгөөд уг хөрөнгө оруулалтаар нийт 4 чиглэлийн 7 багц ажлын нийт 56.2 км авто замын их засварын ажлыг эхлүүлэв.

УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМД НЭМЭЛТ ХОЁР ЭГНЭЭ БАРИХ ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙГ УИХ-ААР БАТЛУУЛАА

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн 3 дугаар үе шатны зээлийн хэлэлцээр болон Европийн сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд нэмэлт хоёр эгнээ зам барих төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрийг тус тус хийж, Улсын Их Хурлаар батлуулав.



ЗАДРАХ БОЛОМЖГҮЙ ХҮНД АЧААГ ДААЦ ХЭТРҮҮЛЭН ТЭЭВЭРЛЭХ ТОХИОЛДОЛД ТӨЛБӨР АВАХ АСУУДАЛД ЗОХИЦУУЛАЛТ ХИЙЛЭЭ



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс төлбөр авах болон улсын чанартай авто замаар задрах боломжгүй хүнд ачааг даац хэтрүүлэн тээвэрлэх тохиолдолд төлбөр авах асуудлыг шийдвэрлүүлснээр Авто замын сангийн болон авто замын засвар, арчлалтын ажилд зарцуулах хөрөнгө орлогыг жилд 3-4 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой боллоо.



АВТО ЗАМЫН ЗУРВАС ГАЗАРТ НЭГЖ ТАЛБАР ОЛГОДОГ БАЙДЛЫГ ЗОГСООЛОО

Улсын чанартай хатуу хучилттай 6980 километр авто замын зурвас газарт хэмжилт хийж, мэдээллийг “Газрын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгүүлснээр зөвшөөрөлгүйгээр авто замын зурвас газарт нэгж талбар олгодог байдал арилж, авто замын зурвас газрыг тус яамны эзэмшилд оруулах нөхцөлийг бүрдүүлэв. Мөн 2023 онд улсын чанартай авто зам, замын байгууламжид буюу нийт 5 чиглэлийн 64 км авто замд гадаргуун боловсруулалт хийх, хучилтыг хүчитгэх, суурийг хүчитгэж хучилтыг шинэчлэх, нүхэн эвдрэлүүдийг засварлах ажлууд хийгдэж байна.



“ТУУЛЫН АВТО ЗАМ ТӨСӨЛ”- ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛАА ЭХЛҮҮЛЭЭД БАЙНА

Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулахад томоохон нөлөө үзүүлэх “Туулын авто зам төсөл”-ийн зураг төслийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд зам барилгын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “барихашиглах-шилжүүлэх” боломжит төрлөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн, төрийн өмчийн концессын зүйл жагсаалтад тусгуулахаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлээд байна.



ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРЫН 11 СТАНДАРТ ШИНЭЭР БАТЛАГДЛАА

2023 оны эхний хагас жилийн байдлаар зам, тээврийн салбарын 11 стандартыг шинээр батлуулсан. Холбогдох стандартчлалын техникийн хороодын хурлаар 20 стандартын төслийг хэлэлцүүлж, батлуулахаар болоод байна.

АВТО ЗАМ ДАГУУ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БАРЬЖ БАЙГУУЛАХ АЖИЛ ҮР ДҮНД ХҮРЧ БАЙНА

Аялал жуулчлалын гол чиглэл дагуу үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг батлагдсан стандарт, зураг төслийн дагуу барьж байгуулах ажлыг үргэлжлүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийт 28 цэгт сонгон шалгаруулалтаар хувийн хувийн хэвшлийн байгууллагууд гэрээ хийж, 6 цэгт бүрэн ашиглалтад оров.

ХАНУЙН ГОЛЫН 109.12 У/М ТӨМӨР БЕТОН ГҮҮР БАРИЛАА

Архангай аймгийн Хайрхан сумын Хануйн голын 109.12 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг Эвт-Уул ХХК хийж байгаа бөгөөд 72%-ийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд дуусган улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө.

Тус гүүр ашиглалтад орсноор Архангай аймгийн иргэд төдийгүй тус чиглэлээр дамжин өнгөрөх зорчигчид, тээврийн хэрэгслүүд бороо, үер устай үеэр түргэн шуурхай, аюулгүй найдвартай зорчих боломж бүрдэнэ.



ӨГИЙННУУР-БАТЦЭНГЭЛ-ИХТАМИР ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ГҮЙЦЭТГЭЛ 85 ХУВЬТАЙ БАЙНА

Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замаас Өгийннуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх 7 км авто замын барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ онд дуусган хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Ашиглалтад орсноор аялал жуулчлалын бүс нутагт иргэд саадгүй зорчих, нөхцөл бололцоо бүрдэж байгаа юм.



ХЯЛГАНАТ ТОСГОН-ХАНГАЛ СУМ ЧИГЛЭЛИЙН ЗАМ 97 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА

Булган аймгийн Хялгант тосгон-Хангал сум чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам 97 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ оны наймдугаар дугаар сард дуусган улсын байнгын ашиглалтад хүлээлгэн өгнө.

ЭЭЛЖИТ БОЛОН ИХ ЗАСВАРЫГ 4 БҮСИЙН 7 ЧИГЛЭЛД ХИЙЖ БАЙНА



Улсын хэмжээнд Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Өндөрхаан, Налайх-Чойр, Мандалговь-Даланзадгад гэсэн 7 чиглэд авто замын их засвар хийж байна.

ХӨГЖИЛД ХӨТӨЛЖ, ДЭВШИЛД ХҮРГЭХ ЗАМЫН СҮЛЖЭЭГ НЭМЖ, хүн зоны хүслийг даллах газрын холыг дөтөлж, ирэх цагийн сайхныг хөдөлмөр зүтгэлээр ойртуулж дөтөлсөн ШИНЭ СЭРГЭЛТИЙН ТҮҮЧЭЭ- ШИНЭ ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ эрхэм ЗАМЧДАДАА амжилт хүсье.

An aerial photograph of a winding asphalt road through a rugged, mountainous landscape. The terrain is rocky and brownish, with some green patches. The sky is clear and blue. Large, white, bold Cyrillic text is overlaid on the image, reading "ОРОН НУТГИЙН АВТО ЗАМЫН СЭРГЭЛТ".

ОРОН
НУТГИЙН
АВТО
ЗАМЫН
СЭРГЭЛТ



ХОВД АЙМАГТ

Ховд-Улаангом чиглэлийн автозам

"Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн 3 дугаар үе шатанд Ховд-Улаангом чиглэлийн 163 км авто замын төслийг хэрэгжүүлэх бөгөөд АХБ-тай байгуулах Зээлийн ерөнхий хэлэлцээрийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан.

Ховд-Ховд сум чиглэлийн автозам


Ховд-Эрдэнэбүрэн сум чиглэлийн автозам
2023.04.25-ны өдөр гэрээ байгуулан, зам барилгын ажлыг эхлүүлсэн. Далан, хиймэл байгууламжийн ажил хийгдэж байна.

Ховд аймгийн орон нутгийн замын арчлалт, засвар


Шинээр барих болон засварлах замуудыг

тодорхойлсон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/152 дугаартай тушаалаар Ховд аймгийн төвийн 3.5 км замыг улсын чанартай авто замын сүлжээнд бүртгэсэн. Шинээр улсын чанартай авто замын сүлжээнд бүртгэсэн замын 1.8 км хэсгийн засвар арчлалтад шаардлагатай 2,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Сайдын 2023 оны А/167 дугаартай тушаалаар шийдвэрлээд байна.

Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км авто замын гүйцэтгэл 24.9 хувьтай байна. Зөөврөөр далан байгуулах, хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах, хоолойн цутгалт хийж байна.



СЭЛЭНГЭ АЙМАГТ



Сэлэнгэ аймгаас Хүдэр сум хүртэлх 9.2 км авто замын барилгын ажил 81 хувьтай. Явган хүний замын суурийг элс хайрганы хольцоор хийх, хашлага тавих, халуун асфальтбетон хольцоор суурь хучилт хийх зэрэг ажлыг хийж байна.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төвийн хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 44 хувьтай байна. Буталсан чулуун суурь байгуулах ажил хийгдэж дууссан. Авто замын хашлага суулгах ажлыг хийж байна.



ГОВЬ-АЛТАЙ
АЙМАГТ



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 16 хувьтай. Ургамлын үе хуулах, ул хөрсийг тэгшилж нягтруулах, зөврөөр далан байгуулах зэрэг ажлыг хийж байна.



ХЭНТИЙ
АЙМАГТ



Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай 52.5 км замын гүйцэтгэл 44 хувьтай байна.

Хэнтий аймгийн Батширээт сумын Бархын голын 121.3 у/м төмөрбетон гүүр, 1.2 км хайрган хучилттай авто замын гүйцэтгэл 52 хувьтай байна.

Өндөрхаан-Норовлин чиглэлийн 62 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 36 хувийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд ашиглалтад оруулна.



Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 30.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Зөврөөр далан байгуулах, ухмал байгуулах, хоолойн ухмал ухах, ул хөрс нягтруулах, зохист ширхэглэл бүхий элс хайрган хольцоор суурь байгуулах зэрэг ажил хийгдэж байна. 2024 онд ашиглалтад оруулна.

Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 130 км замын ажил 74.0%-тай хийгдэж байна.



ТӨВ АЙМАГТ



Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай 122.4 км авто замын төсөл 46.7 хувийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд ашиглалтад оруулна.


Гачууртын авто замын төгсгөлөөс зүүн тийш үргэлжлэх 4.7 км хатуу хучилттай авто замын ажил 68 хувийн гүйцэтгэлтэй. Үндсэн болон түр репер шалгах, хэмжилтийн ажил, хөвөө, явган зам, дугуйн замын суурийн материал тарааж тэгшлэх ажлыг хийж байна.

Борнуур-Дуган хад чиглэлийн 8.5 км хатуу хучилттай авто зам 2023 оны зам барилгын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил үргэлжилж байна.



ХӨВСГӨЛ АЙМАГТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын 8.7 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэл 68 хувьтай. Чулуу бутлуурын угсралтын ажил дууссан. Хоолойн барилгын ажил, суурийн доод үе байгуулах ажил хийгдэж байна.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ

Өвөрхөнгай аймгийн Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км хатуу хучилттай зам

Ургамлын үе хуулах, ул хөрс тэгшилж нягтруулах, Зөөврөөр далан байгуулах, хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах, хиймэл байгууламжийн суурь байгуулах, бетон суурь байгуулах, гүүрийн барилга угсралтын ажлууд хийгдэж байна.



ДОРНОД АЙМАГТ

Дорнод аймгийн Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто зам барилгын ажлыг эхлүүлээд байна.

Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам барилгын ажлыг эхлүүлээд байна.



БУЛГАН АЙМАГТ

Булган аймгийн Дашинчилэн сумын төвийн 1.8 км хатуу хучилттай авто зам
Замын хашлага тавих ажил хийгдэж байна. Газар дээр нь холих аргаар цементээр бэхжүүлсэн суурь байгуулах, асфальтбетон хучилтын ажлууд хийгдсэн.

Булган аймгийн Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 31.08км хатуу хучилттай зам
Ургамлын үе хуулах, тохиромжгүй материал ухаж зайлуулах, зөөврөөр далан байгуулах,

түр зам байгуулах, хоолойн суурийн ухах, зохист ширхэглэл бүхий элс хайрган хольцоор суурь хийх, бетон суурь хийх, хоолойн хэсэглэл суурийн дээр цутгах, толгой далавч цутгах, тулц шал бетон цутгах зэрэг ажлууд хийгдэж байна.

Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн авто замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн авто замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам Ажлын явц 62 хувьтай байна.



АРХАНГАЙ АЙМАГТ



Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажил

Авто замын хөдөлгөөн нээх ажлын хэсгээс хугацаатай үүрэг даалгавар гүйцэтгэгч байгууллагад өгсөн бөгөөд биелэлт 90%-тай явагдаж байна. Нийт ажлын явц 88.03-тай байна.

Архангай аймгийн Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замаас Өгийннуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын эхлэл 3-н замын уулзвар хэсгийг холбох ажлын явц 85 хувьтай байна.

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвийн 7 км хатуу хучилттай авто зам
Уг замын ажил 2023 оны аравдугаар сарын 01-нд дуусна. Өнөөдрийн байдлаар 74.4%-ийн гүйцэтгэлтэй байна.



ДАРХАН-УУЛ АЙМАГТ

Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын аюулгүй байдлыг сайжруулах засварын ажил



ӨМНӨГОВЬ АЙМАГТ



Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477км авто зам төсөл 2023 оны зам барилгын ажлыг 03 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 56.6%-тай байна.

Тавантолгой-гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл/ 2023 оны зам барилгын бэлтгэл ажлыг ханган, 06 дугаар сарын 18-ны өдрөөс зам барилгын үндсэн ажлыг эхлүүлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 63.2 хувьтай байна.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Азийн авто замын АН-4 чиглэлийн Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто зам, гүүрийн барилгын ажлын Багц CW3 хэсэг 11.8 км хатуу хучилттай авто зам, 4.5х4.65м нүхэн гарц 7 дугаар сарын 10-нд ажлыг дуусгахаар ажиллаж байна. Барилгын ажлын явц 85%-тай хийгдэж байна.



УЛААНБААТАР ХОТ



БЗД 1,2,3,7,9,10,11,12,17,19,20,21,22,23,24,27,28 дугаар хороодын дундах хайрган авто зам, явган зам, гэрэлтүүлгийн ажлын явц 98.0%-тай байна.



2023 ОНД ЭХЛҮҮЛЭХ ЗАМ ГҮҮРИЙН ТОМООХОН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Нисэхийн автозамыг Туулын хурдны замтай холбох

Нисэхийн хурдны замаас Наадамчдын зам дээгүүрх 800 у/м гүүр хүртэлх 7.5 км орчим авто замын бүтээн байгуулалтыг ажлыг 2023 онд эхлүүлэхээр бэлтгэл хангаж ажиллаж байна.



МОНГОЛ-ХЯТАДЫН БИЗНЕСИЙН ФОРУМ
МОНГОЛ УЛСЫН ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
С.БЯМБАЦОГТЫН ИЛТГЭЛ:



ХАМТДАА ХОЖИЖ, ХАМТДАА ХӨГЖИХ НЬ

Эрхэм, Хүндэт зочид, төлөөлөгчид өө !
Хатагтай, Ноёд оо !

Монгол Улсын Ерөнхий Сайд Л.Оюун-Эрдэнийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийж буй албан ёсны айлчлалын хүрээнд зохион байгуулагдаж байгаа Монгол-Хятадын бизнес форумд хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улс, БНХАУ-ын хооронд тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа эрчимтэй хөгжиж буй цаг үед Монгол Хятадын бизнес эрхлэгчид чуулж байгаад баяртай байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон Хятадын “Дэлхий нийтийн хөгжлийн санаачилга”, “Бүс ба Зам” санаачилгын зорилтуудыг харилцан уялдуулах, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүү, эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх нь ихээхэн чухал байна.

Монгол, Хятад хоёр бол уул усаар холбогдсон мөнхийн хөршүүд билээ. Манай хоёр улс 2000 жилийн өмнөөс худалдаа наймаа эрхэлж байсан агуу түүхтэй. Мөн бид дэд бүтэц, эрчим хүч, худалдаа, хөрөнгө оруулалтын өргөн

харилцаатай түншүүд. Монгол Улс, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалтаар хоёр улсын худалдааны эргэлтийг 2027 он гэхэд 20 тэрбум ам.долларт хүргэх өндөр зорилтыг дэвшүүлсэн. Зам, тээврийн салбар бол холыг ойртуулдаг, түншүүдийг холбодог, худалдааг эрчимжүүлдэг чухал ач холбогдолтой салбар юм.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны энэхүү “цусны эргэлт”-ийг илүү хурдасган сайжруулахад эдийн засгийн “судас” болсон тээвэр логистик, зам харилцаа, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж, Хятад улсын, цаашлаад даян дэлхийн “эдийн засаг, тээврийн сүлжээ”-тэй олон сэжмээр холбож байж дэлхийн улсуудтай хөл нийлүүлэн хурдтай хөгжиж чадна гэдэгтээ итгэдэг.

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт **БООМТЫН СЭРГЭЛТ**-ийг онцгой анхаарч бодит үр дүн гаргахаар тусгасан.

Өнөөдөр бид хааяа онгойлгодог “САЛХИВЧ” төдий байгаа боомтуудаа хөгжүүлж, байнга нээлттэй “ҮҮД ХААЛГА” болгон өргөжүүлэхийг зорьж байна. Монгол Улс, БНХАУ-тай хуурай газраар хамгийн урт буюу 4700 км урт хилийн зурваст нийт 17 боомтоор холбогдож байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд БНХАУ-тай хиллэж байгаа боомтуудын хүчин чадлыг сайжруулах, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар холбохыг нэн тэргүүнд чухалчлан ажиллаж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Монгол улс шинээр 2,966 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ, 3,358 КМ ТӨМӨР ЗАМ барих, 11 БООМТЫГ АВТО ЗАМААР, 4 БООМТЫГ ТӨМӨР ЗАМААР ХОЛБОХ-ыг зорьж байна.

Энэ хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна.

1. Үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх хүрээнд 2022 онд 897.5 КМ ТӨМӨР ЗАМ бариад байна, Үүнээс Монгол, Хятадын хилийн ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД боомт чиглэлийн 233 км, ХАНГИ-МАНДАЛ боомт чилэлийн 226 км төмөр замыг барьж, ашиглалтад орууллаа. Мөн энэ оны 6 дугаар сард Монгол, Хятадын хилийн ШИВЭЭХҮРЭН-СЭХЭ, БИЧИГТ-ЗҮҮНХАТАВЧ хилийн боомтуудыг төмөр замаар холбох

ажлыг эхлүүлээд байна. Монгол, Хятад хоёр улс 1949 онд дипломат харилцаа тогтоосноос хойш 74 жилийн хугацаанд төмөр замын ганц хилийн боомтоор холбогдож ирсэн бол одоо бид ШИНЭЭР 4 хилийн боомтыг төмөр замаар холбоно.

Төмөр замын зүүн коридорын бүтээн байгуулалтын хүрээнд Орос-Монголын хилээс Эрэнцав-Чойбалсан чиглэлийн төмөр замыг шинэчлэн засварлах, Чойбалсангаас Монгол-Хятадын Бичигт-Зүүнхатавч боомт хүртэлх төмөр замыг шинээр байгуулах том бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр дээрх төмөр замууд холбогдож эдийн засгийн өндөр ач холбогдолтой Монгол-Орос-Хятадыг холбосон төмөр замын зүүн коридор болон хөгжих юм.

Мөн Монгол-Орос-Хятадыг холбосон төмөр замын баруун коридорын бүтээн байгуулалтын хүрээнд 1,255 км төмөр зам барих бөгөөд энэхүү ажлын эхлэх болох Монгол-Хятадын хилийн ШИВЭЭХҮРЭН-СЭХЭ боомтын төмөр замыг эхлүүлээд байна.

Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридорын хүрээнд Улаан-Үдэ Наушки, Сүхбаатар-Замын-Үүд, Эрээн-Жининь чиглэлийн төмөр замын төв коридорын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг харилцан уялдаатай хөгжүүлэхээр гурван улсын хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байна.

Хилийн Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Ханги-Мандал төмөр замын боомтуудыг 1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т тусган шинэчлэн байгуулахаар ЗТХЯ, БНХАУ-ын Улсын төмөр замын газартай хамтран ажиллаж байна. Ингэснээр тус боомтуудын бүтээн байгуулалт дуусмагц төмөр замын улс хоорондын тээвэрлэлтийг гүйцэтгэх боломжтой болно.

2. Авто замын сүлжээг өргөтгөх хүрээнд Монгол-Орос-Хятадыг хатуу хучилттай авто замаар холбосон хоёр дах тээврийн коридор болох Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн Монгол Улсаар дайран өнгөрөх 745 км авто замыг ашиглалтад бүрэн оруулж, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг эхлүүлээд байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд 2011 онд байгуулагдсан “Монгол Улс, БНХАУ-ын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулж байна. Ингэснээр хоёр



улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, гуравдагч улсруу чөлөөтэй тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Эрхэм хүндэт зочид оо,
Хөрөнгө оруулагчид, хамтрагч
түншүүд ээ,
Хятад анд нөхөд өө.

Манай хоёр улсын хоорондын худалдааны эргэлт 2022 онд 13,6 тэрбум ам.долларт хүрсэн бол 2023 оны эхний 5 сарын байдлаар 7,1 тэрбум ам.долларт хүрч тогтвортой өсөн нэмэгдсээр байна.

Мөн 2022 оны байдлаар зөвхөн Европын Холбоо болон БНХАУ-ын худалдааны эргэлт 850 тэрбум долларт хүрсэн бол БНХАУ болон ОХУ-ын худалдаа 2022 онд 190 тэрбум ам долларт хүрч 34.3 хувиар өсчээ.

Энэ бүх өсөлт Монгол Улсын хувьд хилийн боомтуудаа төмөр зам болон хатуу хучилттай авто замаар бүрэн холбож, тээвэр логистикийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, бүс нутгийн хэмжээнд ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох зорилтоо хэрэгжүүлэх нэгэн чухал шалтгаан болж байгааг онцлон тэмдэглэх байна.

Харин энэ зорилтыг хэрэгжүүлэхэд гадаадын тэр дундаа Хятадын хөрөнгө оруулалт, шинэ техник технологи, мэдлэг туршлага, бизнес

эрхлэгчдийн оролцоо туйлын чухал гэдгийн онцлон тэмдэглэе.

Иймээс хөрөнгө оруулагч Та бүхэнд Монгол Улсын зам, тээврийн салбарт хамтарч хэрэгжүүлэх тодорхой төслүүдийг санал болгож байна.

Авто замын чиглэлээр

1. Дархан хотоос МОНГОЛ-ОРОСЫН ХИЛИЙН АЛТАНБУЛАГ БООМТ ХҮРТЭЛХ 113 КМ АВТО ЗАМ, УЛААНБААТАР ХОТООС МОНГОЛ-ХЯТАДЫН ХИЛИЙН ЗАМЫН-ҮҮД БООМТ ХҮРТЭЛХ 640 КМ АВТО ЗАМЫН төслүүд. Эдгээр төслүүд нь Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн хэсэг бөгөөд “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор”-ын хөтөлбөрт багтсан эдийн засгийн өндөр ач холбогдолтой юм.

2. Улаанбаатар хотын шинэ тойрог замын хэсэг болох 35 км ТУУЛЫН АВТО ЗАМ болон 800 у/м ГҮҮРИЙН ТӨСӨЛ. Энэ төсөл нь Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад онцгой чухал ач холбогдолтой.

3. УЛААНБААТАР-“ШИНЭ ХАРХОРУМ” ЧИГЛЭЛИЙН 362 км АВТО ЗАМЫН ТӨСӨЛ. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын эртний нийслэл Хархорин хотыг сэргээн байгуулах төслийн хүрээнд энэхүү төслийн хэрэгжүүлэх юм.

Төмөр замын чиглэлээр

1. Төмөр замын Зүүн болон төв коридорыг холбох САЙНШАНД-БАРУУН-УРТ-ХӨӨТ ЧИГЛЭЛИЙН 431 КМ ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ-ийг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх /DBOT/ хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Төслийн урьдчилсан ТЭЗҮ-г Солонгосын төмөр замын корпорац болон Тээврийн хүрээлэнгийн хамтарсан консорциум гүйцэтгэж байна.

2. УЛААНБААТАР-ХАРХОРИН ЧИГЛЭЛИЙН 384 КМ ХУРДНЫ ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ.

БНХАУ-ын Чайнастэйт констракшин 6-р товчоо компанитай урьдчилсан ТЭЗҮ хийх санамж бичиг байгуулаад байна.

Тээвэр логистикийн чиглэлээр:

Монгол Улс 2023 онд Дэлхийн банкнаас гаргасан Логистикийн индексээр 30 байраар урагшилж 97 дугаар байрт орсон ч цаашид илүү урагшлах, илүү дэвшихийг эрмэлзэж байна.

Иймээс экспорт импортыг нэмэгдүүлэх, худалдааг хөнгөвчлөх ажлыг эрчимжүүлэх үүднээс Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулаг, Чойбалсан, Ховд, Бичигт, Сайншанд гэсэн байршлуудад хуурай боомт, логистикийн төв байгуулах судалгаа, төлөвлөлтийг эхлүүлээд байна.

Мөн БНХАУ-ын Тяньжин хотын ДУНЗЬЯН БООМТ ДАХЬ 10 га газарт Монгол-Хятадын хамтарсан “ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ” байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулагч та бүхнийг урьж байна.

Бид “ШИНЭ ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ТУРШЛАГА, ИННОВАЦ, ҮЙЛДВЭРЛЭЛ”-ийг байнга дэмжих хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах болно.

Энэ хүрээнд Монголд цахилгаан автомашин, түүний тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл эрхлэх, цахилгаан автомашинд зориулсан

цэнэглэх станц байгуулах, зорчигч тээврийн үйлчилгээнд цахилгаан автобус нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх аливаа санал санаачилгыг талархан дэмжихээ илэрхийлье.

Иргэний нисэхийн чиглэлээр:

Монгол Улсын аялал жуулчлалын гол бүс нутаг болох Хөвсгөл, Өмнөговь, Ховд, Дорнод аймгуудын нисэх буудлуудын хөөрөх зуравсыг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулж олон улсын статустай болгох чиглэлээр төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллахад бэлэн байна. Эдгээр 4 нисэх буудлыг олон улсын чиглэлд нислэг үйлдэх эрхтэй нь хувийн хэвшилд шилжүүлэх бөгөөд БНХАУ, ОХУ, Япон, Турк, Азербайжан, Хонгконг чиглэлд нислэг үйлдэх боломжтой болно. Тухайлбал Ховд нисэх буудлаас 23 чиглэлд нислэг үйлдэх юм.

Хүчтэй салхи үлээхэд зарим хүмүүс хана босгож, зарим нь салхин тээрэм барьдаг.

Цар тахлын дараах эдийн засгийн өсөлтийн, эерэг өөрчлөлтийн салхи сэвэлзэн үлээж буй энэ урин цагт Монгол Улс хөрөнгө оруулагчдын өмнө хана хэрэм босгох биш харин хамтдаа “салхин тээрэм” байгуулж, хариуцлагатай, харилцан ашигтай, найрсаг, итгэлт түнш байж, хамтдаа хожиж, хамтдаа хөгжихийг чин сэтгэлээсээ хүсэж байна.

Бидний хамтын ажиллагаа цаашид улам өргөжин, ХАМТДАА ХОЖИХ, ХАМТДАА ХӨГЖИХ, ШИНЭ СЭРГЭЛТ-ийн эхлэл байна гэдэгт итгэл төгс байна.

Монгол Улс Хятадын аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч Та бүхний НАЙДВАРТАЙ ТҮНШ, ИТГЭЛТЭЙ ХАМТРАГЧ байж чадна.

Монгол Хятадын бизнес форумын үйл ажиллагаанд болон хөрөнгө оруулагч Та бүхэнд амжилтын дээдийг хүсэн ерөөе.


ДАЛАЙД ГАРЦГҮЙ Ч ДЭЛХИЙД ГАРЦТАЙ МОНГОЛ

Монгол Улсын эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, Тяньжин боомт дахь Монгол Улсад эзэмшүүлсэн боомтын талбайг үр ашигтай ашиглах тал дээр илүү санаачилгатай, хурдтай байхыг чармайн зорьж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийсэн айлчлалын хүрээнд Боомтын сэргэлт, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогод бодит нөлөө үзүүлж, Монгол Улсын боомтын гарцыг шинээр нэмж бий болгох Тяньжин хот дахь “Монгол, Хятадын тээвэр логистикийн төв” төсөлтэй танилцсан.

Монгол Улс руу тээвэрлэгдэж буй ачаа барааны 80 гаруй хувь нь Бохай тэнгисийн эрэг Тяньжин боомтоос тээвэрлэгддэг. Тяньжин боомт нь ачаа

эргэлтийн хэмжээгээрээ дэлхийд наймдугаарт эрэмбэлэгддэг ба Монгол Улсруу жилдээ 75 мянган чингэлэг ачаа тээвэрлэгддэг. Уг боомт нь үндсэн 8 хэсгээс бүрдэх бөгөөд терминал, гаалийн баталгаат бүс, аялал жуулчлалын бүсийг нэгтгэсэн эко бүс нь Дунзян боомт юм. Дунзяны баталгаат боомтын бүсэд 50 жилийн хугацаатай 10 га газрыг Хятадын талтай хамтран эзэмшиж, ашиглах тухай шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар 2009 онд гаргасан. Монголын талын төлөөллөөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийг давуу эрхтэйгээр оролцуулахаар зааж, “Тяньжин порт групп”-тэй хамтран уг төслийг хэрэгжүүлэх байсан ч харамсалтай нь өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд төсөл хэрэгжихгүйгээр удааширч зогсонги байдалд оржээ.



Уулзалтын үр дүнд

Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн хүрээнд “Тяньжин порт групп”-ийн удирдлагууд төслийг амжилттай хэрэгжүүлэхэд бүхий л талаар хамтран ажиллахад бэлэн байгаа бөгөөд бидний зүгээс шаардлагатай бүх арга хэмжээг авч хоёр талын хамтарсан ажлын хэсгийг яаралтай хуралдуулан төслийн ажлыг эрчимжүүлэхээ илэрхийллээ.

Уг төсөл нь амжилттай хэрэгжсэнээр:

Монголд үйлвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг гуравдагч улс руу тээвэрлэх, борлуулах болон Монгол улсын бусад улс орнуудтай байгуулсан гаалийн болон бусад татваруудын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх маш том боломж бүрдэнэ

• Нүүрс, төмрийн хүдэр болон зэсийн баяжмалын тээвэрлэлтийг хийх, хадгалах, борлуулах



- Мах махан бүтээгдэхүүн бэлтгэх, савлах, боловсруулах, тээвэрлэх, борлуулах
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулах
- Барилгын машин механизмын болон автомашины хил дамжуулах худалдаа эрхлэх зэрэг эдийн засгийн өндөр үр өгөөжтэй юм.

Үүгээр зогсохгүй дэлхийн 180 гаруй улсын 500 орчим боомттой холбогдох боломж нээгдэнэ.

ЗАМ ТЭЭВРИЙН ЦАХИМЖИЛТ

ЦАХИМ ЗАМ ТЭЭВЭР

Цахим үйлчилгээнээс та өөрийн хэрэгцээт мэдээлэл, үйлчилгээ, салбарын судалгаа, түүхэн замнал зэрэг бүх төрлийн үйлчилгээг нэг цонхноос хүссэн үедээ авах боломжтой.



Хайх утгаа оруулна уу...

Зам тээврийн хөгжлийн яамны “ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”-нээс иргэн бүр өөрийн хэрэгцээт нээлттэй мэдээлэл, цахим үйлчилгээ, салбарын судалгаа, мэдээллийн сан гэх мэт бүхий л төрлийн үйлчилгээг нэг цонхноос хүссэн үедээ авах боломжийг олгож байгаа. Энэхүү портал нь үндсэн 5 хэсгээс бүрдсэн.

Нүүр хэсэг:

Эхлэл хэсэгт онцлох үйлчилгээ, сүүлд нэмэгдсэн өгөгдөл болон дашбоардуудтай танилцах боломжтой.

Цахим үйлчилгээ

Цахим шилжилтийн хүрээнд зам тээврийн салбарын цахимаар авах боломжтой бүхий л үйлчилгээг агуулсан байна.

Төрийн болон бизнесийн байгууллагуудын оролцоотой цахимжаад буй бүхий л үйлчилгээг нэг цонхоор хүссэн үедээ авах боломжтой.

Нээлттэй өгөгдөл

Зам тээврийн салбарын нээлттэй мэдээллүүдийг иргэд, олон нийт, судлаачид realtime харж ашиглах боломжтой ба энэхүү нээлттэй өгөгдлүүдийг хүснэгт хэлбэрээр татан авах болон чарт хэлбэрээр харах боломжтой. Өгөгдөл бүр шүүлтэй учир сонирхсон салбарынхаа мэдээллүүдийг

хүссэн шүүлтээр харах боломжтой гэсэн үг юм.

Мэдээллийн сан

Порталын мэдээллийн сан хэсэг нь судалгаа, дүрэм журам, тэтгэлэг, шилэн индексийн үзүүлэлт гэсэн 4 бүрдэл хэсэгтэй.

Судалгаа:

Энэхүү хэсэгт зам тээврийн салбарын бүхий л судалгааг нэгтгэсэн байх ба салбар тус бүрээр шүүх боломжтой. Салбарын дүрэм журам:

Энэхүү хэсэгт зам тээврийн салбарын бүхий л дүрэм журмыг нэгтгэсэн байх ба салбар тус бүрээр шүүх боломжтой.

Салбарын тэтгэлэг:

Порталын энэ хэсэгт зам тээврийн салбарын тэтгэлэгүүдийн мэдээлэл байрлах ба тэтгэлэг олгогч байгууллагын мэдээлэл, тэтгэлэгийн зарлагдсан огноо, дуусах хугацаа, тавигдах шаардлага, бүрдүүлэх материалуудтай танилцан.

Тэтгэлэг зарлагдсан үед анкетаа цахимаар илгээх боломжтой.

Удирдлагууд

Зам, тээврийн салбарын үеийн удирдлагуудын намтарын мэдээллийг харах боломжтой. Эдгээр мэдээллүүдийг цахимжуулснаар хэвлэгдэн гардаг ном товхмол гэх мэт хэвлэлийн зардлыг бууруулж салбарын санг үүсгэн, цахимаар баяжуулах боломжийг бүрдүүлээд байна

Зам тээврийн салбарын Коммунити буюу сонирхлын бүлэг

Сайтын доод буланд байрлах Коммунити гэсэн товчин дээр дарж элссэнээр зам тээврийн салбарын дурын асуулт, сэдвээр сонирхолын бүлгүүд үүсгэн холбогдох албаны хүмүүстэй шууд харьцах боломжтойгоороо үйлчилгээг шуурхай байлгах, иргэдийн дуу хоолойг сонсох боломжийг олгож байгаа.

ДАВУУ ТАЛ, БОЛОМЖ

- Шилэн төрийн суурь болно
- Бүтээмжийг нэмэгдүүлнэ
- Тооцоо судалгаанд суурилсан бодлогын шийдвэр гаргалтыг дэмжинэ
- Зөвхөн Зам тээврийн салбарын бус улсын хэмжээнд уялдаа холбоо бүхий байгууллагуудын

- ажилтан болон иргэдийн ажлыг хялбарчилж, хэмнэлтийг гаргана
- Хүнд суртал, хүний оролцоог бууруулна
- Цаг хугацаа хэмнэнэ
- Чанартай, найдвартай мэдээллийн эх үүсвэрээс мэдээлэл авна
- Иргэдийн санал бодлыг хурдан шуурхай сонсох асуудлыг хэлэлцэх

АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРӨӨ ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ ?

www.roadpay.mn

• Хялбар • Хурдан • Найдвартай

ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛҮҮД

БУХ БАНКНЫ АППЛИКЕЙШН

И-БАРИМТ АППЛИКЕЙШН ГЭРЭГЭ КИОСК МОНПЭЙ АППЛИКЕЙШН QPay WALLET Hi-Pay WALLET

НИЙСЛЭЛ ХОТЫГ ТОЙРСОН 4 ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БҮРЭН ЦАХИМЖУУЛЛАА

ГАЛТ ТЭРЭГНИЙ ТАСАЛБАР ЗАХИАЛГА

Вэб сайт
<http://www.eticket.ubtz.mn>

Аппликэйшн
УБТЗ Тасалбар-UBTZ ticket

Захиалах утас
1900-1949

ЦАХИМ ТАСАЛБАРЫН ЭРЭЛТ ӨНДӨР БАЙНА

Статистик

ЭТХЯ-ийн тэрхийн хэрэгсэлд нийт 18 саяагаар илгээгдсэн өөдө мөдөлийг төлбөр хөнгөлөлттэй байгууламжид барилга засварын ажлын төсөв бодох программыг нэвтрүүлжээ.

Шүүрт

Нийт (33)

Түрээс захиалсан өмчлөгчид ААН

Нийтээр илгээгдсэн төлбөр дотоо бүрэлдэхүүний өмчлөгчид

Өрөө, үйлчилгээ бүртгэл "ТЭТ" ХХК

Аваргын зардалын төлбөрийн өмчлөгчид

Төрийн хөрөнгийн өмчлөгчид

Өөрийн хөрөнгийн өмчлөгчид

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ ПРОГРАММЫГ НЭВТРҮҮЛЛЭЭ



ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛД 1.138.088 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ХАМРАГДАВ



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭРГЭШСЭН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЛЭЭ

AUTOBOX
Simplifiez vous la voiture !

9:41

AUTOBOX

Mon email

Mon mot de passe ou mon code d'activation

Je me connecte

Demander un nouveau code

АУТОВОХ АППЛИКЕЙШНИЙГ АШИГЛАХАД БЭЛЭН БОЛГОЛОО

SmartCar

Ачаа тээврийн түр зөвшөөрөл цахимаар авах зөвлөмж

ТҮР ЗӨВШӨӨРЛИЙН МАТЕРИАЛ ИЛГЭХ ДАРААЛЛ:

SmartCar

АВТО ЗАМЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР ХҮЛЭЭН АВЧ, ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭДЭГ БОЛЛОО



ТОВЧООДЫГ ЦАХИМЖУУЛСНААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ 2 СЕКУНДЭД НЭВТЭРДЭГ БОЛЛОО

Та аян замдаа
Сайн яваарай



УБТЗ Тасалбар
UBTZ Ticket



Зорчигчийн галт тэрэгний нийт тасалбар худалдаалалтын 50 гаруй хувийг цахимаар худалдаалж байгаа төдийгүй цаашид энэ төрлийн үйлчилгээг 70 хувьд хүргэхээр зорьж байна.

Онлайнаар галт тэрэгний тасалбарыг <https://eticket.ubtz.mn> вэб сайтаар, 1900-1949 утсаар болон “УБТЗ-Тасалбар UBTZ-Tasalbar” аппликэйшнээр захиалах боломжтой юм.

УБТЗ-тай хамтран ажилладаг 560 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүд Ачаа тээврийн үйлчилгээний цахим системийг /АТҮЦС/ ашиглаж хэвшээд байна. Энэхүү цахим системийг ашигласнаар УБТЗ-аар үйлчлүүлэгч ачилтын дараалал болон бусад чухал мэдээллийг ил тод нээлттэй мэдэх боломжтой юм.

Зөвхөн энэ оны хоёрдугаар сард
150.748 зорчигч галт
тэргээр зорчсоны
84.020 буюу **55.73%**
цахимаар тасалбар худалдан
авсан байна.

АТҮЦС-ийг ашиглан 2021 онд **1686**
захиалга хийгдсэн бол 2023 оны эхний
улирлын байдлаар **2850**
захиалга хийсэн нь уг системийн
хэрэглэгчийн тоо улам өссөөр байгааг
харуулж байна.

ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРЫН ГАДААД ХАРИЛЦАА СЭРГЭЛТ

“Итгэл даах Түншлэл-Ирээдүйтэй хөрөнгө оруулалт”



ЗАМ ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГАНД 500 ГАРУЙ ТӨЛӨӨЛӨГЧ ОРОЛЦЛОО

Зам, тээврийн хөгжлийн яам, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран “Шинэ сэргэлтийн бодлого-Зам, тээврийн сэргэлт” зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулганыг /2023.06.09/ -ны өдөр зохион байгууллаа. Чуулганаар “Түншлэл-Ирээдүйтэй хөрөнгө оруулалт”, “Хөгжлийн түүчээ-Төмөр зам”, “Хөгжлийн хөтөч-Зам, тээвэр”, “Дэлхийд гарцтай-Агаарын тээвэр” гэсэн сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж, Зам, тээврийн хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагууд, дотоод гадаадын хөрөнгө оруулагчид, ОХУ, БНХАУ-ын 500 гаруй төлөөлөгчид оролцов.

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АЛХМУУД....

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Зочлох жил” болгон зарласантай холбогдуулан агаарын тээврийн либералчлалыг тэлэх зорилтыг дэвшүүлээд буй. Энэ зорилтын хүрээнд 2023- 2024 онд дэлхийн агаарын тээврийн гол бүсүүд рүү шууд нислэг үйлддэг болох шат дараатай ажлыг эхлүүлж, нийт 10 улс оронтой агаарын харилцааны хэлэлцээр



байгуулахаар төлөвлөөд байна. Дээрх ажлыг эрчимжүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2023.04.13-ны өдөр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Ерөнхий сайдын худалдааны элч Даниел Кочинский, Элчин сайд Филип Малон тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, агаарын тээвэр болон төмөр зам, авто замын хөгжлийн чиг хандлага, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцсон юм.



РУМЫН УЛСТАЙ АВТОТЭЭВРИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАНА

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд 2023.04.06-ны өдөр Румын улсаас Монголд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Василика Басил Константинескутай уулзаж, хоёр улсын автотээврийн салбарын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Монгол Улс, Румын Улс хооронд “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулахаар ажиллаж байна. Энэхүү

хэлэлцээр байгуулагдсанаар манай хоёр улсын иргэд, аж ахуйн нэгжүүд харилцан зорчих, худалдаа бизнес эрхлэх, цаашлаад хоёр улсын эдийн засгийн харилцаа, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулах боломжтой юм.




ЗТХ-ийн сайд С.Бямбацогт, ОХУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Алексей Николаевичид сайдаар томилогдсонд баяр хүргээд, хоёр улсын тээврийн салбарын түүхэн харилцааг өргөжүүлж, хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ.

МОНГОЛ, АМЕРИКИЙН ЭДИЙН ЗАСАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛНЭ



Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2023.02.09-нд АНУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ричард Буагантай уулзаж, агаарын тээврийн шууд нислэг, төмөр замын болон далайн тээврийн хамтын ажиллагааны талаар санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрлээ. Хоёр улс хооронд шууд нислэгтэй болсноор эдийн засаг, аялал жуулчлалын харилцаа өргөжин тэлж, иргэд хямд үнээр, богино хугацаанд нисэх боломжтой болно.

МОНГОЛ, ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН “УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ” НИЙГЭМЛЭГИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛААР САНАЛ СОЛИЛЦОВ



Уулзалтын эхэнд ЭТХ-ийн сайд С.Бямбацогт, ОХУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Алексей Николаевичид сайдаар томилогдсонд баяр хүргээд, хоёр улсын тээврийн салбарын түүхэн харилцааг өргөжүүлж, хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. Талууд энэ удаагийн уулзалтаар авто зам, төмөр зам, агаарын тээвэр, авто тээвэр, Богд хаант төмөр зам болон манай хоёр улсын зам, тээврийн салбарт найрамдлын бэлэг тэмдэг болсон Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридор зэрэг өргөн сэдвээр ярилцаж, санал солилцлоо.



ИХ БРИТАНИ УЛСТАЙ АГААРЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛЖ, ШУУД НИСЛЭГТЭЙ БОЛНО

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2023.04.13-нд ИБУИНХ-ын Ерөнхий сайдын худалдааны элч Даниел Кочинский, Элчин сайд Филип Малон тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, агаарын тээвэр болон төмөр зам, авто замын хөгжлийн чиг хандлага, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцлоо. Хоёр улсын худалдаа, эдийн засаг, тээврийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, дээр дурдсан дэд бүтцийн томоохон төслүүдийн хүрээнд манай улстай хамтран ажиллах бүрэн боломжтойг дурдаж, холбогдох албаныхантай хамтран ажиллахаар тохирлоо.



ДЭЛХИЙН БАНКНЫ ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР 50 КМ АВТО ЗАМ ШИНЭЭР БАРЬЖ, 311 КМ АВТО ЗАМ, 5 ГҮҮРЭНД ИХ ЗАСВАР ХИЙНЭ

Төслийн хүрээнд улсын чанартай нийт 311 км авто зам болон таван байршилд төмөрбетон гүүрийн их засвар, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум хүртэлх 15 км авто зам, Архангай аймгийн Булган сум хүртэлх 35 км авто замын ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨНДӨРХААНЫ НИСЭХ БУУДЛЫН ШИНЭЧЛЭЛТИЙН ТӨСЛИЙН НИЙТ ГҮЙЦЭТГЭЛ 70 ХУВЬТАЙ БАЙНА

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2023.05.30-ны өдөр Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн орлогч захирал Иман Абдулраззак тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.




ЦАР ТАХЛААС ХОЙШ АНХ УДАА МОНГОЛ, ХЯТАДЫН ТЭЭВРИЙН САЙД НАР БИЕЧЛЭН УУЛЗЛАА

УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт 2023.06.16-нд БНХАУ-ын Тээврийн сайд Ли Шяопэнтэй уулзав. Уулзалтаар хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа улам эрчимтэй хөгжиж буй энэ цаг үед, төрийн дээд түвшний айлчлалаар дорвитой үр дүн гаргаж, өсөн нэмэгдэж буй худалдааны эргэлтийг хангах, төмөр зам, авто замын холболтуудыг хөгжүүлэх, хилийн боомт, орц гарцуудыг нэмэгдүүлэх, нэвтрүүлэх чадвар, дэд бүтцийг сайжруулахад онцгой анхаарч, тодорхой томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг дээр сайд нар санал нэгдэв.

ОХУ-ЫН ТЭЭВРИЙН САЙДТАЙ УУЛЗАЖ, УБТЗ-ЫН ДҮРМИЙН САНГ 167 ТЭРБУМААР НЭМЭГДҮҮЛЛЭЭ

УИХ-ын даргын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт ОХУ-ын тээврийн сайд В.Савельевтай уулзаж, “Орос-Монголын хамтарсан Улаанбаатар төмөр зам”-ыг байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийн нэмэлт протоколд гарын үсэг зурлаа.

Ингэснээр олон жил яригдсан МОН П1, П2 зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийг цэгцлэх, дуусгавар болох талаар хичээж ажилласны үр дүнд 2009 оноос хойш гацаад байсан асуудалд шийдэл олж, цэг тавилаа.






“SCHOLARSHIP ROAD 2023”

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭНД
2000 ОРЧИМ СУРАГЧ, ОЮУТАН ЗАЛУУС ОРОЛЦЛОО**

УИХ-ын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтын санаачилгаар “Scholarship Road-2023” зам, тээврийн салбарын боловсролын үзэсгэлэн 2023 оны тавдугаар сарын 18-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Үзэсгэлэнд Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа 11 агентлаг, зам, тээврийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг гадаадын болон дотоодын найман их сургууль, коллеж оролцож, тэтгэлэгт хөтөлбөрүүд, нээлттэй ажлын байрны мэдээллээ танилцууллаа.



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**



Хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн
газрын 13 дугаар байр, зип:14251

Утас:
976-(51)263179

Өргөдөл, гомдол хүлээн авах утас:
72005500

Факс:
(976-11)-312315
И-мэйл:
info@mrtdd.gov.mn

Фэйсбүүк хуудас:
<https://www.facebook.com/MRTD.GOV.MN>

Твиттер хуудас:
<http://twitter.com/MrtddGovMn>